

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2001 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч
Ч.Ганбат

Монгол Улсын Дээд шүүхийн эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улиран өнгөрч байгаа 2001 он Монголын нийт шүүх, шүүгчид, шүүхийн байгууллагын ажилтнуудын хувьд үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй хандаж, бодит дүгнэлт өгөх, алдаа дутагдлыг илрүүлж засаж залруулах, хариуцлага, сахилга тооцох их ажлын жил байлаа.

Өнгөрч байгаа онд бид: - Шүүхийн ажиллах эрх зүйн орчинг шинэчлэн боловсронгуй болгох, уг хуулиудын төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах шатанд Дээд шүүх, түүний шүүгчдийн үзэл бодол, байр суурийг өргөн хэмжээгээр тусгуулж, сайн хуультай болгох;

-Шүүхийн ажиллах эдийн засгийн баталгааг бүрдүүлэх, тухайлбал шүүхийн төсөв, шүүгч ажилтнуудын цалин, зэрэг дэвийн нэмэгдэл, шүүхийн албан байр, албаны унаа, холбоо, мэдээллийн сүлжээг ажлын шаардлага хангахуйц түвшинд хүргэх, шүүхүүдийг өргүй болгох талаар Дээд шүүхээс үзүүлж болох нөлөөллийг идэвхжүүлэх;

-Шүүгчийг сургах, давтан сургах систем тогтоох, тухайлбал ХБНГУ-ын “Ханнс-Зайдел”-ийн сангийн хөрөнгөөр Дээд шүүх дээр байгуулсан “Эрх зүйн боловсролын академи”, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн \Соросын сан\-гийн санхүүжилтээр Дээд шүүх дээр ажиллаж байгаа “Шүүгчдийн давтан сургалтын төв”, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр ажиллаж байгаа “Хуульчдын давтан сургалтын төв” -өөр дамжуулан шүүгчдээ сургах, уг сургалтын сэдэв, хөтөлбөр, программыг гаргах, оролцогсдын хүрээг тогтооход Дээд шүүхийн саналыг сайтар тусгуулах, цаашдаа “Шүүгчдыг бэлтгэх, давтан сургах” байнгын, найдвартай, нэгдсэн систем тогтоох;

-Даяарчлал гүнзгийрч, улс орон, байгууллага, компани, иргэдийн маань гадаад харилцаа өргөжин тэлж байгаатай уялдуулан Монголын Шүүхийн гадаад харилцааг хөгжүүлэх, өөрийн шүүхийн ажиллагаагаа бусад улс орны шүүхийн үйл ажиллагаатай уялдуулан, хөгжлийн түвшинг нь ойртуулах зэрэг гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж, анхны бага ч гэсэн өөрчлөлтийг гаргаж байгаа гэж үзэж байна.

Энэ том зорилтыг Дээд шүүх, шүүхүүд дангаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд Монголын төрийн тэргүүн, УИХ, Засгийн газар, ШЕЗ, Гадаад, дотоодын анд нөхдийнхөө дэмжлэг туслалцаатайгаар шийдвэрлэж чадна гэж тооцож ажиллаж байгаа билээ.

2001 он нь Монгол Улсад Шүүх байгуулагдсаны түүхт 75 жилийн ой тохиосон онцлог жил байлаа.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан захирамж гарч энэхүү түүхт ойг ажил хэргийн байдлаар тэмдэглэн өнгөрүүлээ.

Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний нэг гол ажил болох “Шүүх эрх мэдэл – Шинэ зуун” сэдэвт Олон улсын Онол - практикийн бага хурлыг Төрийн ордонд 2001 оны 6 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохиож, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди урилгаар оролцон үг хэлж, мөн манай орны нэртэй эрдэмтэд болон АНУ, ХБНГУ, Япон зэрэг орны эрдэмтэн, профессорууд оролцсон нь ач холбогдол, цар хүрээгээрээ чухал болсон.

Уг Онол практикийн Бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн хэлсэн үг, Ерөнхий шүүгчийн мэндчилгээ, “Шинэ зуун – Шүүх” сэдэвт илтгэлийг Дээд шүүхээс эрхлэн гаргадаг “Монголын төр, эрх зүй” сэтгүүлд хэвлүүлэн нийтийн хүртээл болголоо.

Ойн арга хэмжээний хүрээнд ХБНГУ-ын “Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг”-тэй хамтран Иргэний хууль, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн талаар Улсын Дээд шүүх, нийслэл, дүүргийн нийт шүүгчдийн хүрээнд “Тэрэлж” цогцолборт хамтарсан семинар зохион байгууллаа.

Монгол Улсад шүүх байгуулагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан албан үүргээ сайн биелүүлж байгаа зарим шүүгч, ажилтнуудыг Төр, засаг зохих ёсоор үнэлж, Нийслэлийн шүүхийн шүүгч асан М.Могнооныг Монгол Улсын “Гавъяат хуульч” цол тэмдгээр, Улсын Дээд шүүхийн мэргэжилтэн Р.Ишцог, Ховд аймгийн шүүхийн шүүгч Т.Өнөр, Хэнтий аймгийн шүүхийн шүүгч Д.Цэрэндолгор, Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгч Д.Энхээ, Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Т.Тэрхэнбэ нарын 5 хүнийг **“Алтан гадас”** одонгоор;

Дорнод аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Энхтуяа, Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Б.Баатар, Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Д.Нацаг, Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Д.Эрдэнэбилэг, Булган аймгийн шүүхийн шүүгч П.Төмөрбаатар, Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Ц.Даш, Өмнөговь аймгийн шүүхийн жолооч Б.Готовдорж нарын 7 хүнийг **“Хөдөлмөрийн хүндэт медаль”**-иар тус тус шагнажээ.

Түүнчлэн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2001 оны 48 дугаар тогтоолоор Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгч Д.Батсайхан, Сэлэнгэ аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Л.Баяраа, Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч З.Нацаг, Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Сүрэнжав, Өмнөговь аймгийн шүүхийн шүүгч Л.Ганболд нарын 5 хүнийг **“Шүүхийн тэргүүний ажилтан”** цол тэмдгээр;

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүхийн ахмад ажилтан Б.Чимид, Л.Рэнчин, Г.Совд, шүүгч Н.Төрбат, Судалгааны төвийн захирал Ц.Бүжинлхам нарын 5 хүнийг **“Дээд шүүхийн Хүндэт дэвтэр”**-т нэрийг нь бичиж, **“Дээд шүүхийн хүндэт тэмдэг”**-ээр;

Хууль зүй, Дотоод хэргийн сайдын тушаалаар Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгч Ш.Алтанцэцэг, Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Г.Болормаа, Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгч Ц.Туяа, Орхон аймгийн шүүхийн шүүгч С.Оюунцэцэг, Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгч Н.Гачмаа, Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Г.Сүрэн, Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Р.Хадчулуун, Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Б.Дамба, Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Б.Түмэнбаяр, одоо Улсын Дээд шүүхийн Тамгын хэлтсийн боловсон хүчин, дотоод ажил, зохион байгуулалтын асуудал эрхэлсэн референт Б.Баясгалан нарын 10 хүнийг **“Хууль зүйн албаны тэргүүний ажилтан”** цол тэмдгээр шагнав.

Мөн шүүхийн байгууллагын 200 орчим шүүгч, ажилтан **“Ардын хувьсгалын 80 жилийн ойн медаль”**-иар шагнагдсан явдал нь манай шүүгч, ажилтнуудын ажил хөдөлмөрийн үнэлгээ юм.

Үүний зэрэгцээ зөрчил, дутагдал ч багагүй гарч Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Ж.Энхтуяа шүүн таслах ажиллагаанд удаа дараалан дутагдал гаргаж, сахилгын шийтгэл дахин хүлээсний учир, Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгч Н.Хүрэлбаатар ажлын цагаар удаа дараалан архидан согтуурч, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн, Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Ц.Булганхишиг, Ц.Төмөрцэцэг нар нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон шүүгчийн ёс зүйг удаа дараа зөрчсөн, Булган аймгийн шүүхийн шүүгч Ц.Үнэнбат Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Д.Рэнцэнпэлжид Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн тул дээрх 6 хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчийн албан тушаалаас **огцруулж**;

Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгч Б.Нарандолгор, Д.Цэцгээ, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч Ц.Батчимэг, М.Баярсүрэн, Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгч Р.Сүрэнжав нарын 5 хүнийг мэргэжлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан тул Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчийн албан тушаалаас нь **чөлөөлүүлж**;

Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Б.Сарантуяа, Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгч Т.Баясгалан нарыг эрүүгийн хэрэгт сэжигтнээр татаж шалгах зөвшөөрөл олгон, шүүгчийн бүрэн эрхийг нь тус тус **түдгэлзүүлсэн** Ерөнхийлөгчийн зарлиг гарсан юм.

Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Х.Цэсмаа нь шүүгчдээ мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж чадаагүй, зарим төрлийн хэргийн ялын бодлогыг сулруулсан, шүүгчийн Мэргэшлийн хорооноос түүний мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт өгсөн үнэлгээгээр “шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй”- гэсэн дүгнэлт гарч, ШЕЗ-ын хуралдаанаар хэлэлцэгдэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхөөр Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлээд байна.

Дээрх байдлаас үзэхэд шүүн таслах ажилд алдаа, зөрчил дутагдал үргэлжлэн гарсаар байгаа, хууль болон шүүгчийн ёс зүйн хэмжээг тэр бүр чанд сахин ажиллаж чадахгүй байгаа нь бидний ажлын дутагдлыг харуулж байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан захирамжаар бүх шатны шүүхийн шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаанд үзлэг явуулах журам, үзлэгийг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг батлан аймаг, нийслэл, сум буюу сум дунд, дүүргийн шүүхийн шүүгчдийн шүүн таслах үйл ажиллагааны чанар, шүүгчийн мэргэжлийн ёс зүй, ажлын сахилга, хариуцлагыг 1999-2001 оны 5 дугаар сар хүртэлх байдлаар шалган, 324 шүүгч энэ үзлэгт хамрагдлаа.

Үзлэгт хамрагдсан шүүгчдээс 190 шүүгч “сайн буюу хангалттай”, 127 шүүгч “дунд”, 10 шүүгч “муу буюу хангалтгүй”- гэсэн үнэлгээ авсан байна.

Үзлэгт “муу буюу хангалтгүй” дүн үзүүлсэн 5 шүүгчийг Мэргэшлийн хороонд, 5 шүүгчийг Сахилгын хороонд тус тус шилжүүлж, 4 шүүгчийг өөрсдийнх нь хүсэлтээр зохих хуулийн дагуу тэтгэвэрт нь гаргасан юм.

2001 онд нийт 46 хүнийг шүүгчийн албан тушаалд томилсон ба үүнээс 16 нь дэвшин томилогдож, 41 хүн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний 11 нь өөрийн хүсэлтээр, 23 нь төрийн өөр ажил, албан тушаалд шилжсэн, 7 хүн тэтгэвэрт гарчээ.

Монгол Улсын Дээд шүүхээс санаачлан боловсруулж, ШЕЗ-ийн өргөн мэдүүлснээр УИХ-ын 2001 оны 48 дугаар тогтоолоор “Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрэм”-ийг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү дүрмийг шинэ 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Шүүхийн “Тавдугаар түшээгээс - Тэргүүн түшээ” хүртэлх бүх шатны шүүхийн шүүгчдийн зэрэг, дэвийн нэмэгдэл тус бүрдээ 10%-иар өслөө. Шүүгчдийн зэрэг дэв ахих болзлыг ч шинэ дүрмээр амьдралд ойртуулж, хялбаршуулж өглөө.

УИХ-ын 2001 оны 80 дугаар тогтоолоор бүх шатны шүүхийн шүүгчдийн цалинг энэ оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2500 төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Дээд шүүх 2001 оны нэгдсэн төлөвлөгөөндөө 5 бүлэг 107 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 100 нь бүрэн биелэж, 2 ажил хагас биелэж, 2 ажил хойшлогдсон, 3 ажлыг нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хийх шаардлагагүй болсон байна.

Гэр бүлийн хуулийн тухай болон Татварын тухай хуулиудын зарим зүйл, заалтын талаарх тайлбарын төслийг боловсруулаад Дээд шүүхийн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

ОХУ, Япон, Польшийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ажил төрлийн боломжгүйн улмаас энэ жил манайд айлчлан ирж чадаагүй хойшилсон, АНУ-ын Техас муж улсын Уэслианы Их сургуулийн декан ноён Ричард Гершан, профессор Жой Сбурлок нар 9-р сарын 11-нд АНУ-д болсон алан хядах ажиллагаанаас шалтгаалан айлчлан ирж чадсангүй, шинэ оны 4, 5-р сар хүртэл хойшлогдлоо.

Харин Батлан хамгаалах тухай болон Аудитын тухай, Банкны зээл, тооцоотой холбогдсон хууль, тогтоомжуудад өөрчлөлт орж, Дээд шүүхээс тайлбар авахыг хүсэж байсан асуудлууд нь шийдвэрлэгдсэн учир манайх тайлбар гаргах шаардлагагүй болжээ.

Ерөнхий шүүгч 17 удаагийн хүлээн авалтаар иргэд, хөдөлмөрчид 133 хүнтэй биечлэн уулзаж, санал хүсэлтийг нь сонсож, зохих хариуг өгсөн байна.

Дээд шүүхийн эрүү, иргэний давж заалдах болон хяналтын шатны шүүн таслах ажиллагааны мэдээ гарсан, Эрүү, Иргэний хэргийн танхим, Тамгын хэлтэс, Шүүхийн судалгааны

төвийн тайлан тус тусдаа гарч, тухайн нэгжийн хамт олноороо нэгэнт хэлэлцэгдсэн, түүнд Ерөнхий шүүгч биечлэн оролцсон учир энэ удаад Дээд шүүхийн 2001 оны тайланг товч танилцуулъя.

Нэг. Шүүн таслах ажлын талаар

Монгол Улсын Дээд шүүхийн хуралдааныг 16 удаа зарлан нийт 40 өдөр хуралдуулж, бүгд 504 асуудал хэлэлцсэний дотор эрүүгийн 119, цагаатгалын 105, үүнээс цагаатгагдсан этгээдийн нэр, овгийг зөвтгөх 15, иргэний 250, шүүгчийн сахилгын 7 хэрэг, аймгийн шүүхийг иж бүрнээр шалгасан дүнгийн тухай 6 асуудлыг хэлэлцэж, хуулийн тайлбар 2-ыг гаргалаа.

Түүнчлэн Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнийг сонгох тухай асуудлыг хэлэлцэн, ШЕЗ-ийн гишүүнээр Дээд шүүхийн шүүгч А.Доржготов, Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр нарыг сонгож, Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэн МУИС-ийн ХЗС-ийн багш, “Ханнс-Зайдел”-ын сангийн Монгол дахь төслийн удирдагч, доктор, Ц.Сарантуяа, өмгөөлөгч Ч.Дашням нарыг, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнээр манайд шүүгчээр ажиллаж байсан Ж.Дашдоржийг томилуулахаар УИХ-д санал өргөн мэдүүлж томилуулав.

Завхан, Увс, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор аймгийн болон тэдгээрийн харъяа сум, сум дундын шүүхүүдийн ажлыг иж бүрнээр нь шалгасан дүнгийн тухай асуудлыг Дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцэн 6 тогтоол гаргасан байна.

Үүнийг өнгөрсөн жилтэй харьцуулахад Дээд шүүхийн хуралдаан хийсэн өдөр 11-ээр, хэлэлцсэн асуудлын тоо 55-аар, эрүүгийн хэрэг 20-оор, цагаатгалын хэрэг 3-аар, иргэний хэрэг 45-аар тус тус нэмэгдэж, харин шүүгчийн сахилгын хэрэг 2-оор, хуулийн тайлбар 8-аар тус тус цөөрчээ.

Дээд шүүхээс хуулийн тайлбар гаргах явдал урьд оноос буурсан нь шүүхийн хэрэглэдэг гол хуулиуд шинэчлэгдэхийг харзсанатай зарим талаар холбоотой болно.

Эрүүгийн хэргийн танхим хяналтын журмаар эрүүгийн 638 хэрэг хүлээн авч, түүнийхээ 95.6% буюу 610 хэргийг уншиж хянан хариу өгчээ. Эдгээрийн 478 хэргийг 1 сар хүртэлх хугацаанд, 132 эрүүгийн хэргийг түүнээс илүү хугацаанд уншиж хянажээ.

Дээд шүүхийн хяналтын шатны хуралдаанаар хэлэлцэгдсэн эрүүгийн болон цагаатгалын, “овог нэр өөрчлөх” зэрэг 224 хэргийн 4 нь Ерөнхий шүүгчийн, 157 нь Дээд шүүхийн шүүгчийн, 46 нь Улсын Ерөнхий Прокурорын эсэргүүцэл, дүгнэлтийн дагуу, 17 нь Шүүхийн тухай хуулийн дагуу хэлэлцэгджээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн 224 хэргийн 12.5% буюу 28 тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 27.7% нь буюу 62 нь өөрчлөгдөж, 59.8% нь буюу 134 хэрэг хүчингүй болсны дотор 1930-1940 оны үед шийдвэрлэгдсэн “цагаатгалын хэрэг” 80 байна. Тогтоолыг хүчингүй болгосон 134 хэргийн 19 нь прокурорт, 32 нь шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж, 83 үүний 80 нь цагаатгалын хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Үүнийг өнгөрсөн онтой харьцуулбал хяналтын журмаар хэлэлцсэн эрүүгийн хэргийн тоо 7-оор, таслан шийдвэрлэх тогтоол, магадлал хэвээр батлагдах явдал 1-ээр, өөрчлөлт орох явдал 9-өөр, харин хүчингүй болох явдал 19-аар тус тус нэмэгджээ. Үүний дотор цагаатгалын хэргийн тоо 12-оор, цагаатгагдсан хүний тоо 82-оор нэмэгдсэн үзүүлэлт гарчээ.

Эрүүгийн хэргийн танхим давж заалдах шатаар 247 хэрэг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Давж заалдах журмаар хэлэлцэгдсэн нийт таслан шийдвэрлэх тогтоол, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн 55.9% буюу 138 хэвээр батлагдаж, 27.9% буюу 69 хэрэг нь өөрчлөгдөж, 16.2% буюу 40 хэрэг хүчингүй болсон байна.

Өөрчлөлт орсон 69 хэргийн 5.8% буюу 4 хэргийн зүйлчлэлийг өөрчилсөн, 37.8% буюу 26 хэргийн ял хөнгөрүүлж, 23.2% буюу 16 хэрэгт дэглэмийг бууруулж, 17.4% буюу 12 хэрэгт зүйлчлэлийг хөнгөрүүлж ял хассан, 15.9% буюу 11 хэрэгт бусад өөрчлөлт орсон байна.

Дээд шүүхийн давж заалдах шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 246 буюу 99.6%-д прокурор оролцож, 63 хэрэгт буюу 25.5%-д өмгөөлөгч, 14 хэрэгт буюу 5.7%-д хохирогчийн хууль ёсны төлөөлөгч болон хохирогч, 14 хэрэг буюу 5.7%-д шүүгдэгч оролцсон байна.

Эдгээр үзүүлэлтийг урьд онтой нь харьцуулбал давж заалдах шатаар хэлэлцэгдсэн хэргийн тоо 2-оор буурч, хэвээр батлагдах явдал 8-аар нэмэгдэж, өөрчлөлт орсон хэрэг 4-өөр нэмэгдэж, хүчингүй болсон хэрэг 3-аар буурсан байна.

Нийслэлийн шүүхээс давж заалдах журмаар хэлэлцэгдсэн 98 хэргийн 51.0% буюу 50 нь хэвээр үлдэж, 26.5% буюу 26 хэрэгт өөрчлөлт орж, 22.5% буюу 22 хэргийн таслан шийдвэрлэх тогтоол, захирамж хүчингүй болсон байна. Үүнийг урьд онтой нь харьцуулж үзвэл давж заалдах хурлаар хэлэлцэгдсэн хэргийн тоо адил, хэвээр батлагдсан хэргийн тоо 2-оор өсч, өөрчлөлт орсон хэргийн тоо 3-аар буурч, хүчингүй болсон тогтоол, захирамжийн тоо 5-аар нэмэгдсэн байна.

Төв, Дархан-Уул, Архангай, Баянхонгор аймгийн шүүхийн эрүүгийн шүүн таслах ажлын чанар бусад аймгуудтай харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна.

Эрүүгийн хэргийн танхим 2001 онд 870 өргөдөл, гомдол хүлээн авснаас 91.5% буюу 796-г нь шийдвэрлэж, одоо 74 өргөдлийн үлдэгдэлтэй, 193 өргөдөлийг 1 сараас илүү хугацаагаар хянаж хариу өгсөн байна.

Давж заалдах шатны эрүүгийн хуралдаанд шүүгч М.Дамирансүрэн 46, Б.Дангаасүрэн 36, С.Нямжав 36, Д.Пунцаг 36, Н.Төрбат 29, Д.Батсайхан 26, Б.Доржготов 17, Д.Алтангэрэл 11, Д.Мөнхтуул 10 хэрэг тус тус илтгэж;

Хяналтын шатны хуралдаанд шүүгч Н.Төрбат 72, Б.Дангаасүрэн 44, Д.Пунцаг 30, М.Дамирансүрэн 28, Б.Доржготов 18, С.Нямжав 17, Д.Мөнхтуул 5, Д.Алтангэрэл 6, Д.Батсайхан 4 хэрэг тус тус илтгэж;

Хяналтын журмаар шүүгч Д.Пунцаг 119, С.Нямжав 113, Н.Төрбат 108, М.Дамирансүрэн 89, Б.Дангаасүрэн 87, Д.Батсайхан 29, Б.Доржготов 27, Д.Мөнхтуул 20, Д.Алтангэрэл 18 хэрэг тус тус уншиж, хянан хүргүүлж;

Шүүгч Н.Төрбат 57, Б.Дангаасүрэн 39, М.Дамирансүрэн 24, Д.Пунцаг 23, Д.Батсайхан 24, С.Нямжав 17, Д.Алтангэрэл 5, Б.Доржготов 10 хэрэгт эсэргүүцэл бичжээ. Эдгээр 199 эсэргүүцлээс 38-ыг нь аймаг, нийслэлийн шүүхэд бичжээ.

Хяналтын шатны хуралдаанд оруулсан Дээд шүүхийн шүүгчийн эсэргүүцэлээс шүүгч Н.Төрбат, Д.Пунцагийн тус бүр 3, Б.Дангаасүрэн, М.Дамирансүрэнгийн тус бүр 2, Б.Доржготов, С.Нямжавын тус бүр 1 эсэргүүцэл хангагдаагүй байна.

Шүүгч С.Нямжав **146** өргөдөл, гомдол хүлээн авч, 137-д хариу өгч, үүнээс 36-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 9 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй;

Шүүгч Д.Пунцаг **146** өргөдөл, гомдол хүлээн авч, 137-д хариу өгч, үүнээс 28-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 9 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй;

Шүүгч Н.Төрбат **140** өргөдөл, гомдол хүлээн авч, 121-д хариу өгч, үүнээс 42-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 19 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй;

Шүүгч Б.Дангаасүрэн **127** өргөдөл, гомдол хүлээн авч, 117-д хариу өгч, үүнээс 33-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 10 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй;

Шүүгч М.Дамирансүрэн **123** өргөдөл, гомдол хүлээн авч, 113-д хариу өгч, үүнээс 26-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 10 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй;

Шүүгч Д.Алтангэрэл **63** өргөдөл, гомдол хүлээн авч, 63-д хариу өгч, үүнээс 8-г 1 сараас илүү хугацаатай хянасан;

Шүүгч Д.Батсайхан **53** өргөдөл, гомдол хүлээн авч, 53-д хариу өгч, үүнээс 11-г 1 сараас илүү хугацаатай хянасан;

Шүүгч Б.Доржготов **47** өргөдөл, гомдол хүлээн авч, 39-д хариу өгч, үүнээс 3-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 8 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй;

Шүүгч Д.Мөнхтуул **25** өргөдөл, гомдол хүлээн авч, 16-д хариу өгч, үүнээс 6-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 9 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй гарав.

Эрүүгийн хэргийн танхимын шүүгч нэг бүрийн шүүн таслах ажлын гол үзүүлэлтийг ийнхүү дурьдаж байгаа нь хэн нь ямар ачаалалттай ажилласныг сонордуулж байгаа явдал юм.

Тус танхимын шүүгчдийн ажлын ачаалал харилцан адилгүй, тэнцвэртэй бус байгаа байдал нь шүүгч Д.Алтангэрэл өндөр насны тэтгэвэрт гарсан, шүүгч Б.Доржготов, Д.Мөнхтуул нар томилогдон ажиллаад удаагүй байгаатай холбоотой байна.

Тус танхимын шүүгчдийн тайлангаас үзэхэд шүүгч бүр өөрийн хариуцсан 3-4 шүүхийн 150-756 таслан шийдвэрлэх тогтоолыг уншиж хянасан тоо гаргасан байх боловч энэ ажлыг тогтмолжуулж, чанар үр нөлөөг нь дээшлүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглэе.

Ийнхүү Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид 2001 онд хяналтын журмаар Эрүүгийн болон цагаатгалын 1052 хэрэг хүлээн авч, үүнээс эрүүгийн 610, цагаатгалын 390 хэргийг уншин хариу өгч, давж заалдах шатны хуралдаанаар 254 хэрэг хүлээн авч, 247 хэрэг хэлэлцэж шийдвэрлэн, 7 хэргийн үлдэгдэлтэй шинэ онд шилжиж байна.

Иргэний хэргийн танхим 2001 онд давж заалдах шатаар нийт 13 хэрэг хүлээн авч, өмнөх оны үлдэгдэл 2 хэрэг, нийт 15 хэргийг шийдвэрлэсэн нь өнгөрсөн оныхтой харьцуулахад даруй 33 хэргээр буюу 68,7% буурсан байна. Энэ нь тус танхимыг цаашид хяналтын шатны шүүхийн чиг үүрэгтээ илүү их анхаарал хандуулах боломжтой болсныг харуулж байна.

Давж заалдах шатаар Нийслэлийн шүүхээс иргэний 14 хэрэг, Дархан-Уул аймгаас 1 хэрэг хүлээн авч, бусад аймгаас хэрэг ирээгүй байна.

Давж заалдах шатаар шийдвэрлэсэн иргэний 15 хэргийн 33.3% буюу 5 хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, мөн 40.0% буюу 6 хэргийн шийдвэрт өөрчлөлт оруулж, 26.7% буюу 4 хэргийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Иргэний хэргийн танхим иргэд, байгууллага, өмгөөлөгчийн хүсэлт өргөдөл, албан бичиг 1749 хүлээн авсан нь өмнөх оноос 0.7%-иар өсч, эдгээрийг үндэслэн нийт 1575 иргэний хэрэг татсан нь өмнөх оныхтой харьцуулахад 11.8%-иар өсчээ.

Татсан хэргээс 1172 хэргийн буюу 74,4 хувийн шүүхийн шийдвэр, магадлал үндэслэлтэй зөв байсан учир хариу өгч, Дээд шүүхийн хяналтын хуралдаанд 250, аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын хуралдаанд 60 эсэргүүцэл бичиж, 30 хэрэгт харъяалал тогтоож, 63 хэргийн үлдэгдэлтэй шинэ онд шилжиж байна.

Үүнээс үзэхэд иргэний хэрэгт эсэргүүцэл бичих явдал урьд оноос 26.5 хувиар өссөн бөгөөд энэ нь нэг талаас иргэний хэргийн танхимын шүүгчид доод шатны шүүхийн алдаа зөрчлийг засаж залруулах эрмэлзлэлтэй ажилласныг харуулахын зэрэгцээ, анхан болон давж заалдах шатны шүүх иргэний шүүн таслах ажиллагаанд алдаа гаргасаар байгааг харуулсан баримт юм.

Түүнчлэн ялимгүй шалтгаанаар анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хөндөхөөр эсэргүүцэл бичсэн тохиолдолд ч гарсныг анхаарахгүй байж болохгүй.

Тус танхим иргэний нийт 1575 хэрэг татаж хянасан байна. Энэ нь урьд онд татаж хянасан хэрэгтэй харьцуулбал 11,8%-иар буюу 167 хэргээр өссөн байна.

Дээд шүүхийн иргэний хяналтын шатны хуралдаанаар хянаж шийдвэрлэсэн 250 хэргийн 14 нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн эсэргүүцэлтэй, 224 нь шүүгчийн эсэргүүцэлтэй, 12 нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэлэлцэгдсэн хэрэг байна. Үүнээс 8,8% буюу 22 хэргийн

шийдвэр, тогтоолыг хэвээр үлдээж, 39,2% буюу 98 хэргийн шийдвэрт өөрчлөлт оруулж, 6,8% буюу 17 хэргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, 45,2% буюу 113 хэргийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Иргэний шүүн таслах ажлын ачааллыг 2000 оныхтой харьцуулахад иргэний хэргийн талаар хүлээн авсан өргөдөл, гомдол 13-аар, татаж хянасан хэрэг 167-оор тус тус нэмэгдэж, харин эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанд оруулсан хэргийн тоо 45-аар нэмэгдэж, аймаг, Нийслэлийн шүүхэд бичсэн эсэргүүцэл 18-аар өссөн байна.

Шүүхийн шийдвэр, магадлал хүчингүй болж байгаа гол шалтгаан нь нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулж тайлбар аваагүй, зохигчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болох талаар зар хүргээгүй, мэтгэлзэх эрхийг хангаагүй, бичгийн нотлох баримтад тавих шаардлага хангаагүй, нотлох баримтын зөрүүг гаргаагүй зэрэг ИХШХШ тухай хуулийг зөрчсөн зөрчил зонхилж байгааг анхаарч тус танхим цаашид уг үзэгдлийг таслан зогсоох шаардлагатай байна.

Давж заалдах шатны иргэний шүүх хуралдаанд шүүгч Б.Цогням 5, Д.Данзандорж 3, О.Зандраа 3, А.Доржготов 2, Д.Тунгалаг 1, П.Цэцгээ 1 хэрэг тус тус илтгэж;

Дээд шүүхийн хяналтын шатны иргэний шүүх хуралдаанд шүүгч Ц.Амарсайхан 58, Д.Тунгалаг 46, Б.Цогням 43, А.Доржготов 41, П.Цэцгээ 29, Д.Данзандорж 17, О.Зандраа 12, Р.Жамъянчойжил 4 хэрэг тус тус илтгэж;

Дээд шүүхийн хяналтын шатны хуралдаанд О.Зандраа 12 эсэргүүцэл бичиж;

О.Зандраагийн 1 хэргийн эсэргүүцлүүд тус тус хангагдаагүй хэрэгсэхгүй болгогдсон байна.

Хяналтын журмаар шүүгч , Д.Данзандорж 201, Б.Цогням 190, А.Доржготов 151, П.Цэцгээ 175, Д.Тунгалаг 154, Ц.Амарсайхан 134, О.Зандраа 123, Р.Жамъянчойжил 44 хэрэг тус тус уншиж, хянан хүргүүлж;

О.Зандраа 166 өргөдөл, гомдол хүлээн авч, 143-т хариу өгч, үүнээс 39-г 1 сараас илүү хугацаатай хянасан, 23 өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй;

Ийнхүү иргэний хэргийн танхим 1749 өргөдөл, гомдол хүлээн авч, 1551-ыг барагдуулан хариуг өгч, 198-ын үлдэгдэлтэй шинэ онд шилжсэн байна.

Ерөнхий шүүгчийн 2001 оны 17 дугаар захирамжаар “Улсын Дээд шүүхэд иргэд, хуулийн этгээд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг шинэчлэн баталж мөрдөн ажилласнаар Иргэний хэргийн танхимын шүүгчдийн ажлын ачаалал ойролцоо тэнцвэртэй болсон харагдаж байна.

Тус танхим нь нийт 462 өргөдөл, гомдлыг 1 сараас дээш хугацаагаар хянаж удаашралтай ажилласан явдалд дүн шинжилгээ хийж, цаашид шуурхай шийдвэрлэж, нотлох баримтын болон хууль зүйн үндэслэлтэй дэлгэрэнгүй хариуг өгөхөд анхаарах хэрэгтэй.

Цаашид Дээд шүүхээр хянагдаж байгаа өргөдлийн хугацааг тооцохдоо өргөдөл хэдийд ирэв, хэргийг хэдийд татав, татсан хэрэг хэзээ ирэв, шүүгч хэргийг хэд хоног уншиж хариу өгсөн буюу эсэргүүцэл бичив, түүнээс хойш Дээд шүүхийн хуралдаанд ортол хэд хоног хүлээв, тогтоол нь хэдийд боловсрогдон гарч, хэрэг өргөдлийн хариу хэдийд шууданд хүргэгдэв гэсэн зааг ялгаатай тооцож, өргөдөл, гомдлын карт дээр зохих тэмдэглэл хийж шүүгч, түүний туслах, нарийн бичгийн даргын хариуцлагыг зааглан авч үзэж байвал зохино.

Хоёр. Шүүхийг мэргэжил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар

Нийслэл, орон нутгийн шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн арга зам нь хуулийн тайлбар гарган мөрдүүлэх, тэдний ажлыг шалган туслах, шүүгч, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулах, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс хамтын удирдлага, зохион байгуулалтын аливаа шийдвэр гаргахад нь Дээд шүүх, Ерөнхий шүүгч, Ерөнхий зөвлөлийн гишүүн шүүгчдээс үзүүлэх нөлөөг эрс дээшлүүлэх явдал мөн.

Дээд шүүхээс Шүүхийн Ерөнхий зөвлөлд албан тушаалаар болон та бүхнээс сонгогдож орсон 3 гишүүн гол чухал, асуудлууд дээр нэгдмэл ойлголттойгоор хамтран ажиллаж байгааг тэмдэглэж байна.

Тайлангийн хугацаанд Дээд шүүхийн тайлбар 2-ыг гаргасны дотор Гаалийн болон Гаалийн тарифийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарласан тайлбар, \О.Зандраа, Б.Цогням\, Нийгмийн хамгаалалтай холбогдох хуулиудын зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарласан тайлбар гарсан нь эдгээр хуулийг нэг мөр зөв ойлгож хэрэгжүүлэх, шүүхийн практикийг нэгдмэл тогтооход ач холбогдлоо өгнө гэж үзэж байна.

2002 онд Шүүхийн болон Эрүү, Иргэн, ЭБШ, ИХШХШ тухай зэрэг багц хуулиуд шинэчлэгдэхээр Дээд шүүхийн хууль тайлбарлах бүрэн эрх, Дээд шүүхийн шүүгчдийн сургалт зохион байгуулах үүрэг, роль улам өсөн нэмэгдэж, энэ чиглэлээр хийх ажил бидэнд нэлээн их болно. Нэгэнт батлагдчихсан тааруухан хуулинд тайлбар хийх гэж байхын оронд, одоо эдгээр “хуулиудыг төсөл” байх үед нь Дээд шүүхээс саналаа сайтар өгч, төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байгаа шүүгчид нэн хариуцлагатай ажиллавал зохино.

Шинэ 2002 онд Нийслэл, Дундговь, Төв, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн шүүхүүдэд иж бүрэн, Дорнод, Дорноговь, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл аймаг, нийслэлийн дүүргийн шүүхүүдэд хэсэгчилсэн шалгалтыг хийхээр төлөвлөж байгаа бөгөөд түүний дийлэнхийг нь энэ оны эхний хагас жилд хийхээр төлөвлөж байгаагийн зэрэгцээ заримыг нь Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газартай хамтарч хийх нь илүү үр дүнтэй, ач холбогдолтой байх болно гэж үзэж байна.

Тайлангийн хугацаанд манай шүүгчид давхардсан тоогоор 25 хүн, 135 хоног, 12 аймаг, суманд томилолтоор ажиллаж, дээр дурьдсан аймаг, сум дундын шүүхийн ажлыг иж бүрнээр нь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Говь-Сүмбэр, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган аймгийн шүүх, тэдгээрийн харъяа сум дундын шүүхийн болон Нийслэлийн Багануур, Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүргийн шүүхүүдийн ажлыг хэсэгчилэн болон сэдэвчилэн шалгаж шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр ажилласан байна.

Шүүгчийг мэргэжлийн удирдлагаар хангахад сайтар зохион байгуулсан, орчин үеийн сургалт чухал ач холбогдолтой. Улсын Дээд шүүх дээр “Шүүгчдийн давтан сургалтын төв”-ийг нээж ажиллуулснаар Дээд шүүх болон аймаг, нийслэл, сум, сум дундын болон дүүргийн нийт 80 шүүгчийг 14 хоногийн хугацаатайгаар 4 удаагийн сургалтанд хамрууллаа. Хөвсгөл, Дорнод аймгийн шүүгч, ажилтнуудад Шүүхийн тухай багц хуулийн үзэл баримтлалын асуудлаар 7 хоногийн сургалтыг шүүх дээр нь очиж зохион байгуулж 40 шүүгч, туслах ажилтнууд уг сургалтанд хамрагдлаа.

Шүүгчийг мэргэжлийн удирдлагаар хангахад Дээд шүүхийн тогтоол, Эрүү, Иргэний хэргийн танхимын магадлал, энгийн магадлал, Шүүхийн судалгааны төвөөс гаргаж байгаа хагас, бүтэн жилийн статистик мэдээ, судалгаа, шүүхийн практик судалсан талаарх тойм, зөвлөмж, танилцуулга, мэдээлэл, Онол - практикийн илтгэл, өгүүлэл, эмхтгэл, гарын авлага, Дээд шүүхээс гаргаж ирсэн “Монголын төр эрх зүй”, “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлд нийтэлж буй материалууд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн санхүүгийн дэмжлэгээр “Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл”-ийн 2-р дэвтрийг хэвлүүлэн, бүх шатны шүүхийн нийт шүүгч, зарим ажилтнуудад албаны хэрэгцээнд нь үнэ төлбөргүй тараан өглөө.

Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбар, шүүхийн практикийг хуулийн дагуу нэг мөр, зөв тогтооход ач холбогдол бүхий таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, мөн шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор гаргасан Ерөнхий шүүгчийн захирамж, танхимуудын зөвлөмж, шүүхүүдийг шалгаад гаргасан тогтоол, протокол зэргийг Мэдээллийн Нэгдсэн санд оруулж, уг санг байнга нийт шүүгчид, хуульчид, иргэд, байгууллага, албан тушаалтнууд ашиглах боломжтойгоор, нээлттэй, тогтмол ажиллуулахаар АНУ-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийнхөнтэй харилцан тохиролцож ажлаа эхлээд байна.

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах, шинэ 2002 онд шүүхийн байгууллагын шийдвэрлэх зорилтыг тодорхойлж, цаашид хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын жил бүрийн “Ээлжит цугларалт”, “Нэгдсэн зөвлөлгөөн”

ямагт чухал ач холбогдолтой байдаг. Үүнд одооноос сайтар бэлтгэж, Аймаг, нийслэлийн 22, сум болон сум дунд, дүүргийн 38 шүүх, одоо ажиллаж байгаа нийт 350 шүүгчийн ажил байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, байр эзлүүлэн урамшуулж, Ерөнхий шүүгч нарын Нэгдсэн зөвлөлгөөнийг шинэ оны 1 дүгээр сарын сүүлч, 2 дугаар сарын эхэн үед хийх явдал нь бидний тайлангийн жилд хийсэн ажилдаа дүгнэлт хийж, цаашид хэрхэн ажиллахаа тодорхойлоход чухал ач холбогдолтой. Үүнд танхимууд одооноос сайтар бэлтгэх хэрэгтэй байна.

Гурав. Тамгын хэлтсийн ажлын талаар

Дээд шүүхийн Тамгын хэлтэс нь 2001 онд шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг явуулах хэвийн нөхцлийг бүрдүүлэх, батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зохих зүйл, ангиар нь үр ашигтай зарцуулах, ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхийн тулд сургалт зохион байгуулах, Ерөнхий шүүгчээс Тамгын хэлтсийн ажлын талаар өгсөн 5 бүлэг, 25 төрлийн үүргийг хэрэгжүүлэх, танхимууд, Тамгын хэлтэс, Нэгдсэн зөвлөлгөөн дээр шүүгч, ажилтнуудаас тавьсан санал, хүсэлтийн мөрөөр ажил зохиох, жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар анхааран, бодитой үр дүнтэй ажиллаж ирлээ.

Тамгын хэлтсийн даргын зөвлөл 8 удаа хуралдаж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин, албан ажлын онцгой нөхцлийн, зэрэг дэвийн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин болон ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоох, ажилтнуудад болон тэтгэвэрт байгаа ахмадуудад буцалтгүй тусламж үзүүлэх, ажилтнуудад цалинтай, цалингүй чөлөө олгох, байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогын дүн зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ирлээ.

Зарим шүүгч ажилтнуудыг төрийн дээд одон, медаль болон бусад байгууллагын шагналаар шагнуулахаар тодорхойлох, зарим хүмүүсийг ажилд томилох, чөлөөлөх, “Дээд шүүхэд иргэд, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулж, тэдэнд хариу өгөх журам”, “Иргэд, өмгөөлөгчид, байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авах хуваарь”-ийг Танхимуудтай хамтран шинэчлэн боловсруулж, Ерөнхий шүүгчийн захирамжаар батлуулан, Дээд шүүхийн нийт шүүгч, ажилтнуудад мөрдүүлэн ажиллаж байна.

Нийт шүүх, шүүгчдийн өнгөрсөн жилийн ажлын дүнг үзүүлэлтийн дагуу гарган байр эзлүүлж, тэднийг шагнаж урамшуулах тухай асуудлыг боловсруулж шийдвэрлүүлсэн. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын Нэгдсэн зөвлөлгөөний хөтөлбөрийг боловсруулж, бэлтгэл ажлыг ханган “Ханнс-Зайдел”-ийн сантай хамтран “Нүхт” цогцолборт зохион байгууллаа.

Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, төрийн үйлчилгээний албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан бөгөөд байгууллагын шүүгч, ажилтнуудын хувийн хэргийн баяжилтыг хийж цэгцэлсэн байна.

Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсээс зохион явуулсан Архивын галын үзлэгт “Хангалттай” дүн авчээ.

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Дэд бүтцийн хяналтын албанд хүсэлт тавьж, Дээд шүүхийн конторын барилгын чанар, газар хөдлөлийг даах тэсвэртэй байдал, галын болон цахилгаан, түүнчлэн сантехникийн аюулгүй байдлын талаар үзлэг хийлгүүлж, 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 192, 2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 55/280 тоот дүгнэлтүүдийг гаргууллаа.

Дээд шүүхийн албан ажлын хэрэгцээнд ашиглах боломжгүй болсон Эрүү, Иргэний хэргийн танхимын 2 автомашиныг дуудлага худалдаагаар худалдах, Тамгын хэлтсийн 1 автомашиныг актлуулах тухай асуудлыг Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлсний үр дүнд 3744.3 сая төгрөгийг төсөвтөө оруулан, шүүхийнхээ автомашинуудын запас, сэлбэгэнд зарцуулсан. Төрийн өмчийн хорооны тогтоолоор 33,0 сая төгрөгийн үнэтэй “Ниссан патрол”- машиныг балансаас балансад шилжүүлэн авсан нь одоо Ерөнхий шүүгчийн албан ажилд үйлчилж байна.

Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн 11 хүнийг ажил, албан тушаалаас нь чөлөөлж, өндөр насны тэтгэвэрт 3 хүнийг гаргаж, тэдгээрийн оронд 13 хүнийг шинээр ажил албан тушаалд томилон ажиллуулж байна.

Дээд шүүхийн залуучуудын санаачилгаар энэ оны 3-р сараас Залуучуудын зөвлөл байгуулагдсанаасаа хойш Дээд шүүхийн удирдлага, ШЭМШХ төсөл, Эрх зүйн шинэтгэлийг дэмжих Хуульчдын төв болон Нийслэл, дүүргийн шүүхийн ажилтан залуучуудтай тодорхой хүрээнд хамтран ажиллаж “Шүүхийн шинэтгэл ба туслах ажилтнуудын оролцоо” сэдэвт чөлөөт ярилцлагыг зохион байгууллаа.

Улсын Дээд шүүхийн тамгын хэлстийн даргын 2001 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 35 дугаар тушаалаар байгуулсан тооллогын комисс нь ажлын 14 хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгийг карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг нярав – нягтлан бодогчийн бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр 310 нэрийн 86,2 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, 173 нэрийн 79,9 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, 90 нэрийн 4,1 сая төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, 80,3 сая төгрөгийн үнэтэй 6 автомашин, 79,3 сая төгрөгийн үнэ бүхий 1290 ширхэг орос ном, 2,3 сая төгрөгийн үнэ бүхий 501 нэрийн 788 ширхэг англи ном, 42 нэрийн 47 ширхэг герман ном, бүгд 3724 ном тоологдов. Акталж данснаас хасах шаардлагатай эд хөрөнгийн жагсаалт гарган, Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл авч шийдвэрлэхээр болов.

Дээд шүүх нь улирч буй 2001 онд **185.1** сая төгрөгийн төсөв батлуулж, санхүүжилтээ бүрэн авлаа.

Нийт батлагдсан төсвийн **52.0** сая төгрөг нь хөрөнгө оруулалтын, **133.1** сая төгрөг нь урсгал зардлын төсвийн хөрөнгө байлаа.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд **5 325.0** мянган төгрөг төсөвлөснөөс **6 532.8** мянган төгрөг зарцуулагдсан бөгөөд **1 207.8** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гэрэл цахилгааны зардалд **2 501.8** мянган төгрөг төсөвлөснөөс **2 174.5** мянган төгрөг зарцуулагдсан ба **327.3** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Түлш халаалтын зардалд **13 242.7** мянган төгрөг төсөвлөгдсөнөөс **8 814.2** мянган төгрөг зарцуулагдаж, **4 28.5** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Тээвэр шатахуун **5 969.2** мянган төгрөг төсөвлөснөөс **5 942.0** мянган төгрөг зарцуулагдсан ба **27.2** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Шуудан холбооны зардалд **7 212.4** мянган төгрөг төсөвлөснөөс **12 804.3** мянган төгрөг зарцуулагдсан ба **5 591.9** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Цэвэр, бохир усны зардалд **905.2** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **1 018.1** мянган төгрөг зарцуулагдаж, **112.9** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Ном, хэвлэл авах зардалд **720.0** мянган төгрөг төлөвлөснөөс **928.4** мянган төгрөг зарцуулагдаж, **208.4** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Албан томилолтын зардалд **1 200.0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **1 858.0** мянган төгрөг зарцуулагдаж, **658.0** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Урсгал засварын зардалд **500.0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **800.0** мянган төгрөг зарцуулагдсан ба **300.0** мянган төгрөгөөр **хэтэрсэн** байна.

Хөрөнгө оруулалтын **52.0** сая төгрөгөөс, **28.0** сая төгрөгөөр эрүү, иргэний хэргийн танхимд “Соната – 5” маркийн суудлын автомашин 2-ыг авч, үлдэх **24.0** сая төгрөгөөр конторын 1.2 дугаар давхарын болон конторын барилгын дээврийн засварыг хийлгэсэн байна. Барилгын гадна талын засвар, гол хаалгыг шинэчлэн солиход **0.8** сая төгрөг байгууллагаас зарцуулжээ.

Дээд шүүхийн батлагдсан төсвийн зарим зүйл анги, тухайлбал бичиг хэрэг, шуудангийн зардал төлөвлөснөөс 1,2 сая төгрөгөөр хэтэрч байгаа нь Санхүү, эдийн засгийн яам манай байгууллагын эдгээр зардлыг бусад яам, газрынхтай адилтган үзэж, төсвийг жил бүр хасаж ирсэнтэй холбоотой байв.

Төсөв хөрөнгийн зарцуулалтанд сар бүр дүн шинжилгээ хийж, ялангуяа телефон утасны зардал хэтэрч байсныг багасгах зорилгоор гар утастай харьцах утасны тоог цөөрүүлж, зарим утсанд сард 10,0 мянган төгрөгийн лимит тогтоолоо.

Ийнхүү байгууллагын төсөв зарим зүйл, ангиараа хүрэхгүй хэтэрсэн ч бусад зүйл, ангийн хэмнэлтээрээ нөхөж, тайлангийн жилд төсвийн зардлыг нийт дүнгээр нь хэтрүүлэлгүй ажиллаж чадлаа.

Улсын Их Хурал Дээд шүүхийн шинэ 2002 оны төсвийг **151.868.100** төгрөгөөр баталсан бөгөөд үүний **10.0** сая төгрөг нь хөрөнгө оруулалтын төсөв юм.

Дээрх байдлаас үзэхэд шинэ онд манай байгууллага төсвийн хувьд хүрэлцээ муутай, аль болох төсвөө хэмнэж, ажиллах шаардлагатай байна.

Дөрөв. Шүүхийн судалгааны төвийн ажлын талаар

Тус төв 2001 онд Улсын Дээд шүүхийн төлөвлөгөөгөөр 27, төвийн жилийн төлөвлөгөөгөөр 40 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөж үндсэнд нь биелүүлжээ.

Улсын Дээд шүүхээр хэлэлцэгдэж өөрчлөгдөж, хүчингүй болсон шийдвэрүүд, улсын хэмжээгээр сүүлийн 5 жилд оногдуулсан ялын байдал, эд зүйл, спирт, согтууруулах ундааны зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн хэрэгт оногдуулсан ялын байдал, малын хулгайн хэрэгт сүүлийн 3 жилд оногдуулсан ялын байдал, Дээд шүүхийн шүүгчдээс сүүлийн 2 жилд бичсэн эсэргүүцлийн биелэлт, шүүхээс 5 жилд шийдвэрлэсэн иргэний хэргийн өсөлт, бууралт, банкны нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдал, Захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэглэж буй шүүхийн практик, Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийг хэрэглэж буй шүүхийн практик зэрэг асуудлаар судалгаа хийжээ.

Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах, ялыг өөр хөнгөн ялаар солих журмыг шүүхийн практикт хэрхэн хэрэглэж байгааг Төв аймаг, Баянзүрх дүүргийн шүүх дээр шалгасан нь үр дүнтэй болсныг тэмдэглэж байна.

Иргэний хэрэгт нотлох баримтыг гаргуулах, цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэхэд шүүгчдээс анхаарах асуудлын талаар Ерөнхий шүүгчийн албан даалгаврын төсөл боловсруулаад байна.

Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгааг улсын хэмжээгээр судлан тойм бичив.

Ийнхүү тайлангийн хугацаанд тус төвийн мэргэжилтэн – шүүгчийн туслах нар бүгд 11 зөвлөмж, 12 тойм, 27 танилцуулга бичиж, орон нутгийн шүүх болон Дээд шүүхийн удирдлагад танилцуулсан байна.

Улсын хэмжээний эрүү, иргэний шүүн таслах ажлын 2000 он, 2001 оны эхний хагас жилийн статистик мэдээг нэгтгэн дүгнэж танилцуулга, хэвлэлээр мэдээлэл гаргав.

Хууль тогтоомжийн системчилсэн лавлагааг тогтмол хийж Улсын Их Хурлаас баталсан 85 тогтоол, 53 хууль, Засгийн газрын 250 тогтоолыг эмхтгэн, орсон нэмэлт өөрчлөлтүүдийг хийж шүүгч ажилтнуудыг мэдээллээр хангаж ирлээ.

Тус төвийн ажилтнуудыг “шүүгчийн туслах”, “судалгааны мэргэжилтэн” гэж шинэчлэн хувиарласнаар тус төвийн 6 ажилтан шүүгчийн туслахаар ажиллаж тайлангийн хугацаанд эрүү, иргэний 942 хэрэг хянаж 233 эсэргүүцэл, 57 тогтоол, 26 танилцуулга, 112 захирамжын төсөл боловсруулж, 144 албан бичиг төлөвлөж, 562 өргөдөл гомдолд хариу өгч, 176 хүнтэй уулзжээ.

Тав. Гадаад арга хэмжээ, сургалт семинарын талаар

2001 онд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахууд болон Тамгын хэлтсийн ажилтнууд гадаад, дотоодод болсон сургалт, семинаруудад идэвхтэй оролцлоо. Тухайлбал:

Ерөнхий шүүгч Ч.Ганбат Шинэ Зеланд улсын Крисчурч хотноо болсон Ази, Номхон далайн орнуудын Ерөнхий шүүгчдийн IX Бага хурал, ОХУ-ын Санкт-Петербург хотноо Дэлхийн банкнаас зохион байгуулсан семинарт оролцсоны гадна, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сантай хамтран ажиллах тохиролцооны дагуу "Монголын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинэтгэл хөтөлбөр"-ийн хүрээнд ХБНГУ-ын Мюнхен хотод "Холбооны хууль зүйн яам болон шүүхийн бүтэц, эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоо" сэдэвт сургалтанд Эрүүгийн хэргийн Танхимын тэргүүн шүүгч Д.Батсайхан, шүүгч Д.Алтангэрэл, Д.Пунцаг, Б.Дангаасүрэн, М.Дамирансүрэн, Н.Төрбат нарын хамт оролцсоны гадна, Монгол Улсын Дээд шүүх, Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Нидерландын Вант улсын "Эрх зүйн Олон улсын хамтын ажиллагааны төв"-ийн тохиролцооны дагуу Нидерланд улсын Лайден хотноо болсон "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр" сэдэвт сургалтанд шүүгч Д.Пунцаг, Б.Цогням, О.Зандраа, А.Доржготов нар оролцлоо.

Түүнчлэн Нидерланд улсын Амстердам хотноо болсон "Жендер ба Олон улсын шүүхийн механизм" сэдэвт семинарт шүүгч П.Цэцгээ, ХБНГУ-д Шүүх, прокурорын байгууллагын ажлын туршлага судлах ажлаар шүүгч Б.Доржготов, АНУ-ын Юта мужийн Бригхэм Юнгийн Их сургуульд болсон "Шашин шүтлэг, үзэл бодлоор үл гадуурхах тухай 1981 оны тунхаглалын хэрэгжилтийн тухай" Олон улсын Бага хуралд шүүгч Ц.Амарсайхан нар оролцжээ.

Ерөнхий шүүгч АНУ-ын элчин сайд Жон Дингер, ХБНГУ-ын Хууль зүйн сайд хатагтай Херта Дойблер Гмелин, элчин сайд Шрёдер, ОХУ-ын Хууль зүйн яамны 1 дүгээр орлогч сайд Евдокимов тэргүүтэй зочид төлөөлөгчид, ХБНГУ-ын Бремен мужийн захирагч, Сенатын тэргүүн, Хууль зүйн сайд, доктор Хеннинг Шерф нар, ОУП Холбооны Хүний эрхийн хорооны дэд ерөнхийлөгч Шриланкийн парламентийн гишүүн Махинда Самара Сингх, Английн хуульч Жозеф Мидльтон, Польшийн СЕМ-ийн Үндсэн хуулийн хариуцлагын комиссийн дарга Ежигивич, Ханнс Зайделийн сангийн тэргүүн дэд захирал Райнер Гепперт, Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төслийн зохицуулагч хатагтай др.профессор Ц.Сарантуяа, Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн зохицуулагч Роберт Ла Монт, Дэлхийн банкны шугамаар ирсэн Ази, Номхон далайн бүсийг хариуцсан төлөөлөгч Карло Эскудеру, Хүний эрхийн хорооны нарийн бичгийн дарга Инго Борг Шварц, Шүүгчдийн давтан сургалтын төвийн шугамаар ирсэн Голландын шүүгч багш нар зэрэг гадаадын 50 гаруй зочид, төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, ажил төрлийн ярилцлагууд хийсэн байна.

Монгол банкт хамтран "Банкны хууль тогтоомж", Гаалийн Ерөнхий газартай хамтран "Гаалийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нэг мөр ойлгох, зөв хэрэглэх", Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газартай хамтран "Шүүхийн шийдвэрийн биелэлт", Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газартай хамтран "Үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь", Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран "Хүний эрх- Шүүх ба өмгөөлөл" сэдэвт семинарыг зохион байгуулж, шүүгчид, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нар, холбогдох байгууллагын төлөөлөгчид оролцсон нь чухал ач холбогдолтой болсон.

Мөн Шүүхийн шийдвэр биелүүлэх Ерөнхий газрын харъяа хорих 405, 409, 401 дүгээр ангиудад Улсын Дээд шүүхийн 13 шүүгч очиж гяндан, чанга дэглэмтэй хорих ангиудад хоригдлууд хэрхэн ял эдэлж буй байдалтай танилцсан явдал нь цаашид ялын бодлогод бодитой хандахад ач холбогдолтой боллоо.

Манай шүүгч, ажилтнууд өөрсдийн мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх, ялангуяа гадаад хэл сурах талаар онцгой анхаарч, шамдан суралцаж байгаа нь сайшаалтай байна. Тухайлбал:

"Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн төслийн хүрээнд "Сантис боловсролын төв"-ийн гадаад хэлний сургалтын Англи хэлний 6 сарын дамжаанд шүүгч П.Цэцгээ, шүүгчийн туслах Ц.Цогт, С.Одгариг, Н.Дуламсүрэн, кодификаторч Ц.Нарангэрэл нар, Улсын Дээд шүүх дээр АНУ-ын "Адвокат интернейшнл" байгууллагын дэмжлэгтэйгээр зохион явуулж буй Англи хэлний сургалтанд шүүгч Д.Мөнхтуул, шүүгчийн туслах Ц.Цогт, Н.Дуламсүрэн, Б.Оюунбилэг, П.Машбаяр, нарийн бичгийн дарга Г.Оюунгэрэл, Д.Батбаатар, номын санч Д.Туяа нар суралцаж байна.

Бичиг хэргийн эрхлэгч Ж.Тэгшдэлгэр Засгийн Газрын Хэрэг эрхлэх газраас зохион явуулсан "Бичиг хэргийн ажилтнуудад зориулсан программ хангамж"-ийн 3 хоногийн сургалтанд, архив хариуцсан ажилтан Ц.Цэнгэлмаа Хансс-Зайделийн сангийн "Эрх зүйн боловсрол" академиас зохион явуулсан 3 хоногийн сургалтанд тус тус хамрагдсан байна.

Цаашид ч сургалтууд үргэлжлэх болно.

Дээд шүүхийн эрхэм шүүгч, албан хаагчид аа! Та бүхэнд Монгол Улсын Дээд шүүхээс 2001 онд хийсэн ажлын тайланг товч танилцууллаа.

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажилласан шүүгч Ц.Амарсайхан, Б.Цогням, Д.Пунцаг, Судалгааны төвийн мэргэжилтэн, шүүгчийн туслах Ц.Ичинхорлоо, Г.Буяннэмэх, цагаатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Очиржав, Судалгааны төвийн тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэг, хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, бичээч Д.Оюунчимэг, жолооч Г.Батчулуун, үйлчлэгч Д.Уртнасан, Ц.Цэцэгсүрэн, Я.Болорсүвд нарт хамт олныхоо өмнөөс талархал илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь амжилт хүсье.

Эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улирч буй 2001 онд бид багагүй зүйл хийж амжуулсан ч, шинэ 2002 онд хийх зүйл түүнээс ч их байна.

Иймд Улсын Дээд шүүх, Шүүхийн байгууллагын өмнө шинэ 2002 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт: Монгол Улсын Их Хурлаас батлагдсан "Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлыг улам эрчимтэй үргэлжлүүлэх шаардлагатай байна.

Ялангуяа 2000 оноос эхлэн стратеги шинжтэй зорилт болгон тавьж ирсэн, энэхүү тайлангийн эхэнд дурьдсан:

-Шүүхийн ажиллах эрх зүйн орчинг шинэчлэж боловсронгуй болгож, сайн хуультай болохын хэрээр шүүхийн үйл ажиллагаанд шинэчлэл хийх;

-Шүүхийн ажиллах эдийн засгийн баталгааг бүрдүүлэх;

-Шүүгчийг бэлтгэх, сонгон шалгаруулах, сургах, давтан сургах, байнгын, найдвартай, нэгдсэн систем тогтоох;

-Шүүхийн гадаад харилцааг өргөжүүлж хөгжүүлэх, шүүх, шүүгчийн ажиллагаанд гадаад орны шүүхүүдийн тэргүүний арга барилыг нэвтрүүлэх замаар Монголын шүүхийн хөгжлийн түвшинг бие даасан, хараат бус шүүхийг төлөвшүүлсэн бусад улс орнуудын шүүхийн хөгжлийн түвшинд ойртуулах үндсэн зорилтуудыг хэвээр үргэлжлүүлж, тодорхой үр дүнд хүрэх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, Эрүүгийн хэргийн танхим 2002 онд дараах зорилтыг хэрэгжүүлбэл зохино:

1. Эрүүгийн болон ЭБШ хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхэд Дээд шүүхээс урьд нь хууль тус бүрт 3 удаа бичгээр өгсөн санал, Дээд шүүхийн байр суурийг сайтар тайлбарлан оролцох;

2. Хүнд, онц хүнд гэмт хэрэг, хүн амь, бусдыг санаатай хүнд гэмтээх, дээрэмдэх, онц хүндрүүлэх шалтгаантай хулгай, малын хулгай, онц хүндрүүлэх шалтгаантай танхай, спирт, эд зүйлийг их хэмжээгээр болон хүндрүүлэх шалтгаантайгаар улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, хээл хахууль, албан тушаал, хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар худалдаалах, наймаалах, олон тооны ан хууль бусаар агнасан хэрэг, хүний амь хохироосон авто аваарын хэрэг зэрэг нийгмийн хор аюул, гаралт нь өсөж байгаа хэрэгт оногдуулах ялын бодлогыг хуульд тодорхойлсон төрөл, хэмжээнд нь оногдуулж байх. Олны анхаарал татсан ээдрээ будлиантай хэргийг шүүхүүд хуулийн дагуу, нээлттэй ил тодоор, зөв шийдвэрлэдэг болгох. Хууль, ёс зүй

зөрчсөн шүүгчийг Сахилгын хороонд, мэдлэг чадварт нь эргэлзээ төрвөл Мэргэшлийн хороонд тухай бүр нь шилжүүлж зохих шийдвэр, дүгнэлт гаргуулж ажиллах;

3.Эрүүгийн болон ЭБШ хууль батлагдмагц уг хуулийн талаар сургалт хийх, уг хуулийн талаарх албан ёсны болон онолын тайлбарыг боловсруулж гаргахад шүүгч, туслахуудынхаа хүч анхаарлыг төвлөрүүлэх. Ерөнхий шүүгч захирамж гаргаж, ажлын хэсэг байгуулж энэ ажлыг дэмжих болно.

4.Цагдан хорих зөвшөөрлийг шүүгч олгох, Дээд шүүхийн эрүүгийн хяналтын шатны хуралдааныг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр, хяналтын журмаар, гомдол гарсан тохиолдол бүрт хийх болж, анхан шатны болон Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын ажлын ачаалал эрс нэмэгдэх төлөвтэй байгааг одооноос тооцож, уг ажлын орон тоо, зохион байгуулалтын бэлтгэлийг хэрхэн хангах талаар тодорхой санал боловсруулж, ажил хэрэг болгох,

Гуравдугаарт, Иргэний хэргийн танхим:

1.Иргэний болон ИХШХШ болон иргэний шүүн таслах ажиллагаатай холбоотой бусад хуулийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхэд Дээд шүүхээс урьд хууль тус бүрт 1-3 удаа бичгээр өгсөн санал болон Дээд шүүхийн байр суурийг сайтар тайлбарлан таниулж оролцох;

2.Хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, иргэний хэргийн нотолгоог зохигчдын хүсэлтээр гүйцэт бүрдүүлж, зохигчдыг шүүх хуралдаанд бүрэн оролцуулж, тэдний мэтгэлцэх эрхийг хангах замаар, хуулийн хугацаанд нь анхан шатанд нь үндэслэлтэй зөв шийдүүлж байх, нэгэнт ингэж шийдсэн хэргийн шийдвэрийг үл ялих шалтгаанаар хөндөхгүй байх бодлогыг баримтлах. Хууль, шүүгчийн ёс зүй зөрчсөн шүүгчийг сахилгын хороонд, мэдлэг чадвар муутай шүүгчийг тухай бүр нь мэргэшлийн хороонд шилжүүлж, зохих дүгнэлт, шийдвэрийг гаргуулж ажиллах;

3.Иргэний хэрэг, түүнтэй холбоотой гарсан өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэж, баримт нотолгоог дурьдаж заасан, хуулийн тодорхой зүйл, заалтыг баримтлан дэлгэрэнгүй хариуг өгч байх, гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг уг асуудлыг уламжилсан, мэдээлэл авахыг хүссэн байгууллага, албан тушаалтан, телевиз, радио, хэвлэл мэдээллийн байгууллагад тодорхой мэдээлж ажиллах;

4.Иргэний болон ИХШХШ хууль батлагдмагц уг хуулийн талаар сургалт хийх, уг хуулиудын талаарх албан ёсны болон онолын тайлбар гаргахад шүүгчдийнхээ хүч, анхаарлыг хандуулах. Ерөнхий шүүгч захирамж гарган, ажлын хэсэг байгуулж, бүх талын дэмжлэг үзүүлэх болно.

5.Захиргааны шүүхийг байгуулж ажиллуулах, түүнд ажиллах 70 гаруй шүүгчдийг сургаж бэлтгэхэд тус танхимын дэмжлэг туслалцаа чухал гэдгийг санаж, үүнд ямар дэмжлэг үзүүлэхээ тооцоолж бэлэн байх нь зүйтэй.

Дээд шүүхийн иргэний хяналтын шатны хуралдааныг тус танхимын 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр, хяналтын журмаар гомдол гарсан тохиолдол бүрт хийх болж, ажлын ачаалал эрс өсч болзошгүйг одооноос тооцож, зохион байгуулалтын бэлтгэлтэй байх ёстой.

Дөрөвдүгээр, Тамгын хэлтсийн хувьд:

1.Дээд шүүхийн барилгыг засварлах, Авто паркийг шинэчлэх зорилт биелэсэн учир шинэ 2002 онд гол анхаарлаа байгууллагын дотоод ажлын уялдаа холбоо, эмх цэгцийг сайжруулах, байгууллагын дотоод журам, ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх, ажлын ачааллыг жигдрүүлэх, ажлын хариуцлага сахилгыг өндөржүүлэх, Дээд шүүх, танхимууд, шүүгчдийн өмнө тавигдаж байгаа зорилгыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглүүлэх;

2.Эрүү, Иргэний танхимын хяналтын шатны хуралдаан хийх заалтыг тохижуулах, Дээд шүүхийн хуралдааны танхимыг ХБНГУ-ын "Ханнс-Зайдел"-ийн сангийн дэмжлэгтэйгээр тохижуулах ажлыг хийж дуусгах, байгууллагын сантехникийн засварыг хийх;

3.Ерөнхий шүүгчээс үүрэг болгож өгсөн таван бүлэг, 25 төрлийн багц ажлаас дутуу зүйлийг хийж дуусган, танимууд, Шүүх судлалын төв, Тамгын хэлтсийн ажилтнуудаас ажил дүгнэх

зөвлөлгөөн болон энэхүү Нэгдсэн зөвлөлгөөн дээр тавьсан хүсэлтийг судлаж шийдвэрлэж, хамт олонд хариу мэдээлэх.

Тавдугаарт, Шүүх судлалын төвийн хувьд:

1.Танхимууд, шүүгчидтэй ажлаа нягт уялдуулж, Дээд шүүх, шүүхийн өмнө тулгамдсан асуудлуудын учир шалтгааныг тухайн цаг хугацаанд нь, улсын хэмжээнд болон тодорхой шүүхэд хэсэгчлэн судалж, судалгааны дүн нь Дээд шүүхийн тайлбар, Ерөнхий шүүгчийн захирамжийн эх болж байхаар тооцож ажиллах;

2.Багц хуулиудыг шинэчлэгдэн батлагдахаар Шүүхийн статистик мэдээ, судалгааны маягтуудыг шинжлэх ухаан, Онол – практикийн үндэслэлтэйгээр боловсруулан гаргаж батлуулах;

3.Шүүгчийн ажлын ачааллын норматив хот, хөдөөд ямар байхыг ШЕЗ болон холбогдох яамдтай Онол – практикийн үндэслэлтэй боловсруулан эрх бүхий байгууллагаар батлуулах, шүүх, шүүгчдийн ажлыг үнэлэх, дүгнэх шалгуурыг боловсруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэх нь зүйтэй.

Эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Эдгээр зорилтуудыг өөрийн арвин мэдлэг, дадлага туршлагаараа баяжуулж, Монголын шүүхийн шинэчлэлийн төлөө нэгдмэл санаатай, гар нийлж ажиллацгаая!

Анхаарал тавьсанд баярлалаа.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ХЭЛТСИЙН 2001 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2001.12.26

Улаанбаатар хот

Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын хэлтэс нь 2001 онд шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн нөхцөлд тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлэх, батлагдсан төсвийн хөрөнгийг зохих зүйл ангиар нь үр ашигтай зарцуулах, ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхийн тулд сургалт зохион байгуулахад гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллалаа.

Нэг.Удирдлага, зохион байгуулалт, дотоод ажлын талаар

Тамгын хэлтэс нь 2001 онд Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс тамгын хэлтсийн ажлын талаар өгсөн 5 бүлэг 25 төрлийн үүргийг хэрэгжүүлэх, танхимууд, тамгын хэлтсийн болон нэгдсэн зөвлөлгөөн дээр шүүгч, ажилтнуудаас тавьсан санал, хүсэлтийн мөрөөр ажил зохиох, Дээд шүүхийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд үндсэн ажлаа чиглүүлэн ирлээ.

Нэгдсэн төлөвлөгөөндөө хийж гүйцэтгэхээр 37 ажлыг төлөвлөснөөс, 35 ажил нь бүрэн биелэгдэж, хэвлэл – мэдээллийн төлөөлөгчгүйгээс шалтгаалан сүүлийн хагас жилд Улсын Дээд шүүхэд хэвлэл мэдээллийн албыг байгуулж, радио, телевизийн нэвтрүүлгийг тогтмол явуулах ажил зохион байгуулах болон телевиз, радио, сонин хэвлэлээр гарч байгаа санал, гомдол, шүүмжлэлийг бүртгэн авч анхааралтай хандан зөрчлийг засуулах, үндэслэлгүй зүйлд няцаалт өгөх зэрэг 2 ажил дутуу биелэсэн байна.

Тамгын хэлтсийн даргын зөвлөлийн хуралдааныг 8 удаа хийж, уг хуралдаанаар Ерөнхий шүүгчээс зайлшгүй, нэн даруй хэрэгжүүлэх ажлын талаар өгсөн үүрэг болон нэгдсэн зөвлөлгөөн дээр шүүгч, ажилтнуудаас тавьсан санал, шүүмжлэлийн мөрөөр зохиосон ажлын талаар хэлэлцэж, уг ажлыг эрчимжүүлэх тухай үүрэг, даалгаврыг холбогдох ажилтнуудад өгч, биелэлтэнд нь хяналт тавьж ажилласнаас гадна шүүгчид, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоох, зэрэг дэв, бүх төрлийн нэмэгдлүүдийг олгох, тэдэнд мөнгөн тусламж, шагнал – урамшуулал болон цалинтай, цалингүй чөлөө олгох, ажилд томилох, чөлөөлөх, байгууллагын эд аж ахуйн тооллогын дүн, шүүхийн төсвийн орлого, зарлагын дүн зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Дээд шүүхэд иргэд, хуулийн этгээд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам болон өргөдөл, гомдлыг нь хуулийн хугацаанд, чирэгдэлгүй барагдуулах зорилгоор тэдний төлөөлөгчид, өмгөөлөгчдийг хүлээн авч цагийн хуваарийг Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимуудтай хамтран шинэчлэн боловсруулж, Ерөнхий шүүгчийн захирамжаар батлуулан, Улсын Дээд шүүхийн нийт шүүгч, ажилтнуудад мөрдүүлэн ажиллаж байна.

Төрийн захиргааны албаны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, төрийн үйлчилгээний албаны албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж мөрдүүлээ. Мөн түүнчлэн шүүгч - ажилтнуудын бүх хувийн хэрэгт баяжилт хийж, цэгцэллээ.

Өргөдөл, гомдлын ажил хариуцсан мэргэжилтэн эрүүгийн 870, иргэний 1749, тамгын хэлтсийн 41, нийт 2660 тооны өргөдөл, гомдлыг хүлээн авч, карт нээн хугацаанд нь шийдвэрлүүлэхээр холбогдох шүүгч, ажилтнуудад өгч, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна. Хүлээн авсан өргөдөл, гомдлоос 2388-ыг нь барагдуулж, 655 нь хугацаа хэтэрсэн байна.

Бичиг хэргийн эрхлэгч 1996 албан бичиг, 3700 хавтас хэрэг, шуудангаар ирсэн 725 өргөдөл хүлээн авч, карт нээн холбогдох шүүгч, ажилтнуудад өгч шийдвэрлүүлснээс гадна 6200 албан бичигт дугаар өгч, холбогдох байгууллагад нь явуулжээ.

Бичээч нар 754318 мөр буюу 26986 хуудас бичгийг компьютер болон бичгийн машинаар бичсэн байна.

Компьютерийн төвийн ажилтнууд 2000 оны 7 дугаар сараас хойш гарсан хууль, хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг программд нэмж оруулан, Шүүхийн судалгааны төвийн захирал Ц.Бүжинлхам, шүүгч Б.Цогням, “Эрх зүйн боловсрол Академи”-ийг байгууллагын компьютерийн дотоод сүлжээнд холбон ажиллуулсан байна. Хяналтын шатны шүүх хуралдааны материал болон бусад зайлшгүй шаардлагатай 26067 хуудас материалыг олшруулснаас гадна “Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 1, 2, 3, 4; “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийн 1, 2 дугааруудын эхийг бэлтгэн хэвлэлд шилжүүлж шүүхийн байгууллагуудын утасны жагсаалт, сэтгүүлийн бланк, судалгааны төвийн бланк, аж ахуйн маягт, ажилтнуудын хаалганы хаяг зэргийг шинэчлэн хийснээс гадна программ зохиогч нь Улсын Дээд шүүхийн сүлжээний толгой компьютерийг сольж, гадаад, дотоод сүлжээнд холбон өргөдөл, гомдлын бүртгэлийн программ, иргэний хэргийн бүртгэлийн программ зэргийг шинэчилж, эрх зүйн актуудын Вебсайтыг хийсэн байна.

Ерөнхий шүүгчийн туслах, Ерөнхий шүүгчийн захирамж 72, тамгын хэлтсийн даргын тушаал 97, ерөнхий шүүгчийн эсэргүүцэл 20, шүүгчийн захирамж 281, эсэргүүцэл 479-т тус тус дугаар өгч, ёсчлон бүртгэлд авчээ.

Түүнчлэн урьд оны 1200 гаруй хуудас бүхий 5 хавтас материалыг архивын нэгж болгон архивт шилжүүлснээс гадна давхардсан тоогоор 12 аймаг, сум, нийслэлийн дүүргүүдэд ажилласан 25 хүнд албан томилолтын хуудас олгож, Ерөнхий шүүгчийн өдөр тутмын үйл ажиллагаанд биечлэн тусалж ажилласан байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлын хэсэг 449 өргөдөл хүлээн авч, Тагнуулын Ерөнхий газрын архив, Үндэсний төв архив, аймгийн архивуудаас 344 хэргийг татан авч, цагаатгалын ажил хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилан шийдвэрлүүлснээс одоо 43 өргөдлийн үлдэгдэлтэй байна. Энэ онд аймгуудын цагаатгалын комисс болон ард иргэдэд 730 цагаатгалын үнэмлэх бичиж олгосноос гадна аймаг, сумдын цагаатгалын салбар комиссуудаас цагаатгалын үнэмлэх хүссэн 203 албан тоот хүлээн авч, 195 албан тоотод хариу өгчээ. Нөхөн олговрын 158 шийдвэрийг аймгуудын шүүхүүдээс хүлээн авч, хэлмэгдэгсдийн судалгааны төвд хүргүүлсэн байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын болон давж заалдах шатны шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, уг хуралдаанаас гарсан магадлал, тогтоол, тэмдэглэл зэргийг цаг хугацаанд нь ёсчлон, иргэд, хуулийн этгээд, байгууллагуудад хүргүүлсэн байна.

Иргэний хэргийн танхимын нарийн бичгийн дарга хяналтын 1237 өргөдлийн дагуу аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхүүдээс 1505 хэрэг татан, бүртгэлд авч, шүүгч нарт хуваарилан өгч шийдвэрлүүлэн, 1250 хэргийн тоотыг нийлж, шүүгч нараар ёсчлуулан холбогдох шүүхүүдэд болон өргөдөл гаргагчид хариу хүргүүлсэн байна. Мөн Давж заалдах шатны хуралд 15 удаа, иргэний хэргийн танхимын хэрэг хэлэлцэх зөвлөлгөөн болон хуралдаанд 108 удаа оролцон, тэмдэглэл хөтөлснөөс гадна хэргийн харъяалал тогтоох 54 шүүгчийн захирамжийг төлөвлөн, шүүгч нараар ёсчлуулан, холбогдох шүүхүүдэд хүргүүлсэн байна.

Эрүүгийн хэргийн танхимын нарийн бичгийн дарга хяналтын 483 өргөдлийн дагуу хэрэг татах тоотыг аймаг, нийслэл, дүүргийн шүүхүүдэд явуулж, 588 хэргийг хяналтын журмаар хүлээн авч, бүртгэлд оруулан шүүгчдэд хуваарилан шийдвэрлүүлж, 555 хэргийг эмхэтгэн холбогдох шүүхүүдэд явуулснаас гадна давж заалдах шатны журмаар 253 хэрэг хүлээн авч, бүртгэлд оруулан давж заалдах шатны 244 шүүх хуралдаанд оролцож, протокол хөтөлж, 241 хэргийг эмхэтгэн холбогдох шүүхүүдэд хүргүүлж, 79 мэдэгдэх хуудсыг ШШБЕГ азарт хүргүүлжээ.

Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хяналтын шатны 16 шүүх хуралдаанд оролцон, тэмдэглэл хөтөлж, уг хуралдаанаас гарсан 503 тогтоолыг нийлж бүртгэлд авч, тогтоолын хувиудыг холбогдох шүүхүүдэд нь хүргүүлжээ. Мөн түүнчлэн эрүү, иргэн, цагаатгалын 474 хэргийг үдэж цэгцэлсэн байна.

Номын сан хариуцсан ажилтан 25 нэрийн 50 ш монгол ном, 24 нэрийн 26 ширхэг орос ном, 17 нэрийн 26 ширхэг англи ном бүгд 102 ширхэг номыг номын сангийн бүртгэлд шинээр авч, зохих журмын дагуу ажиллагаа хийн, 29 ширхэг номыг сэлбэн засварлаж, шинэ номын мэдээллийг 15 удаа гарган уншигчдад танилцуулж, шүүгч - ажилтнуудад 68 нэрийн 318 ширхэг номыг гэрээр олгон ашиглуулж, уншлагын танхимд давхардсан тоогоор 294 хүнд 1218 ширхэг ном, 1345 ширхэг сэтгүүлээр үйлчилж, байгууллагын захиалсан 3 нэрийн орос сэтгүүл, 6 нэрийн монгол сонинг ангилан цэгцэлж, 45 хүнд уншигчийн үнэмлэх олгон ажилласан байна.

Байгууллагын бичиг хүргэгч нь 520 албан бичиг, 1608 хавтас хэрэг, 20 зарлан дуудах хуудсыг холбогдох иргэд, хуулийн этгээд, байгууллагад нь хүргэн, гардуулан өгсөн байна.

Архив хариуцсан ажилтан шүүгч - ажилтнуудын 2000 онд хөтлөгдсөн материалуудыг хүлээн авч, цэгцлэн архивын 32 нэгж болгон бүртгэлд авч, 45 шүүгч, ажилтанд архивын баримтыг ажлын хэрэгцээнд зориулан түр хугацаагаар ашиглуулж, тамгын хэлтсийн даргын болон шүүгчдийн зөвшөөрлийг үндэслэн 8 хүнд архивын баримтыг хуулбарлан өгсөн байна.

Мөн Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсээс зохион явуулсан “Архивын галын үзлэг”-т хангалттай гэсэн үнэлгээ авч, анхааруулга авагдсан дутуу байгаа гэрэлтүүлэг, стандартын, галын хортой болгох гэсэн шаардлагыг бүрэн биелүүллээ.

Шүүгч, ажилтнуудын хэвийн ажиллах нөхцлийг хангах, эрүүл мэндээ хамгаалах нөхцлийг анхаарч, байгууллага дээр мэргэжлийн эмч гэрээгээр ажиллуулж, их эмч Бумцэнд нь 2001 онд 578 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна. Мөн түүнчлэн давхардсан тоогоор 6 хүнд зүү эмчилгээ, 18 хүнд төөнө засал, 13 хүнд банк, 192 хүнд бариа, массаж, гар засал, 7 хүнд соронзон зүү, 83 хүнд тариа, 156 хүнд УВЧ шарлага, 10 хүнд боолт, 14 хүнд дасгал зэрэг эмчилгээнүүдийг хийснээс гадна 49 хүнд монгол эм өгч, 51 хүнд эмийн жор бичиж, 16 хүнийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд явуулсан байна.

Монгол Улсын Дээд шүүхийн тухай товч танилцуулгын эхийг бэлтгэн, Ерөнхий шүүгчид хянуулахаар өгөөд байна.

Тамгын хэлтсийн орон тоо, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх ажлыг судалж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр зарим ахмад хүмүүсийг тэтгэвэрт гаргаж, зарим залуу боловсон хүчнийг шилж сонгон ажилд томиллоо.

Төрийн захиргааны албанд түр хугацаагаар томилогдон ажиллаж байсан хүмүүсийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтанд оруулж, Ерөнхий шүүгчийн туслах П.Машбаяр, Хангамжийн асуудал хариуцсан референт-менежер С.Баасанцэрэн, цагаатгалын ажил хариуцсан операторч Ц.Ариунболд нар шалгалтанд тэнцэж, төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөж дээрхи албан тушаалд жинхлэн ажиллаж байна.

Монгол Улсын Дээд шүүхийн залуучуудын санаачлагаар Дээд шүүхийн дэргэдэх “Залуучуудын зөвлөл” энэ оны 3 дугаар сард байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. “Залуучуудын зөвлөл” нь байгуулагдсан үеэсээ эхлэн Улсын Дээд шүүхийн удирдлага, “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төсөл, “Эрх зүйн шинэтгэлийг дэмжих Хуульчдын төв” төрийн бус байгууллага болон Нийслэл, дүүргийн шүүхүүдийн ажилтан залуучуудтай тодорхой хүрээнд хамтран ажиллаж байна. Улсын Дээд шүүх, Нийслэл, дүүргийн шүүхүүдийн ажилтан, залуучуудын дунд “Шүүхийн шинэтгэл ба туслах ажилтнуудын оролцоо” сэдэвт чөлөөт ярилцлага, төрөл бүрийн урлаг, спортын уралдаант тэмцээнийг зохион явуулсан байна. Тухайлбал: Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан Нийслэл дүүргийн шүүхүүдийн хэмжээнд гар бөмбөг, олс таталт зэрэг тэмцээн, хөгжилтэй тоглоом, шилдэг “Онигооч” шалгаруулах, бүжиг, дууны зэрэг урлагийн арга хэмжээнүүдийг зохион явуулж, манай хамт олон амжилттай оролцлоо.

Хуулийн төв байгууллагуудын дунд \Үндсэн Хуулийн Цэц, Улсын Дээд шүүх, Хууль зүй, Дотоод хэргийн яам, Хүний Эрхийн Үндэсний комисс, Улсын Ерөнхий Прокурорын газар, Монголын Өмгөөлөгчдийн холбоо\ жил бүр уламжлал болон зохиогддог “Шилжин явах цомын төлөө тэмцээн”-ийг энэ жил Шинэ Үндсэн хуулийн 10 жил, Хууль зүйн алба байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан Улсын Ерөнхий Прокурорын газраас зохион явуулахад гар бөмбөг, сагсан бөмбөг, биллиард, боулинг, ширээний теннис, шатарын тэмцээнүүдэд манай баг тамирчид амжилттай оролцож, гар бөмбөгийн тэмцээнд манай баг 1 дүгээр байр эзэлж “Алтан медаль”, теннисний тэмцээнд эрэгтэй баг тэргүүлж “Алтан медаль”, эмэгтэй баг гуравдугаар байр эзэлж “Хүрэл медаль”, сагсан бөмбөгийн тэмцээнд эрэгтэй баг 2 дугаар байр эзэлж “Мөнгөн медаль” тус тус хүртэж, багуудын нийлбэр дүнгээр буюу 32 оноогоор 3 дугаар байр эзэллээ.

Дээрхи урлаг, спортын уралдаант тэмцээнүүдэд Дээд шүүхийн хуралдааны бичгийн дарга Д.Батбаатар, үйлчлэгч Я.Болорсүвд, Б.Уртнасан, бичээч С.Наранцэцэг, жолооч Б.Батсүлд нар

бусдаасаа илүү идэвхи, зүтгэлтэй оролцож мөнгөн шагналаар шагнагдсаныг тэмдэглэх нь зүйтэй байна.

2001 он нь Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 75 жилийн ой тохиосон онцлог жил байлаа. Энэ тэмдэглэлт, түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан захирамж гарч, уг захирамжийн дагуу ажил хэргийн шугамаар тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд ойн гол арга хэмжээ болох “Шүүх эрх мэдэл - Шинэ зуун” сэдэвт Олон Улсын онол – практикийн бага хурлыг Төрийн ордны “Б” танхимд амжилттай зохион байгуулахад Тамгын хэлтсийн ажилтанууд идэвх, зүтгэл, санаачлага гарган оролцлоо.

Монгол Улсын бүх шүүгчдэд “Монгол Улсын нэрийн өмнөөс” гэсэн хавтасыг Ханнс-Зайделийн сангийн санхүүгийн туслалцаатайгаар хийлгэн шүүгчийн нөмрөгийн салшгүй хэсэг болгон зөвхөн шүүх хуралдаанд хэрэглэж байхаар бүх шүүхүүдэд хүргүүлжээ.

Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан улс болон шүүхийн байгууллагад он удаан жил, идэвхи зүтгэл, үр бүтээл, санаачлага гарган ажилласан зарим шүүгчид, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг төрийн одон, медаль, байгууллагын шагналд тодорхойлон шагнуулав. Тухайлбал: Тамгын хэлтсийн ажилтнуудаас, шүүгчийн туслах Р.Ишцог “Алтан гадас” одонгоор, Шүүхийн судалгааны төвийн захирал Ц.Бүжинлхамыг Улсын Дээд шүүхийн “Хүндэт дэвтэр”-т бичиж, алдрыг нь мөнхжүүлэн “Дээд шүүхийн Хүндэт тэмдэг”-ээр, цагаатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн, шүүгчийн туслах М.Чойням, судалгааны төвийн мэргэжилтэн, шүүгчийн туслах Г.Буяннэмэх, Ерөнхий шүүгчийн туслах Ц.Цогт, Бичиг хэргийн эрхлэгч Ж.Тэгшдэлгэр, номын санч Б.Туяа, кодификаторч Ц.Нарангэрэл нар Улсын Дээд шүүхийн “Жуух бичиг”-ээр, нарийн бичгийн дарга Б.Энхбаатар, бичээч С.Наранцэцэг, үйлчлэгч Б.Уртнасан нар Улсын Дээд шүүхийн гэрчилгээ, мөнгөн шагналаар, төрийн захиргааны болон үйлчилгээний нийт 12 албан хаагч Ардын Хувьсгалын 80 жилийн ойн “Хүндэт медаль”-аар тус тус шагнагдлаа.

2001 онд тамгын хэлтсийн даргын тушаалаар төрийн захиргааны болон үйлчилгээний албанд 11 хүнийг ажилд томилж, 13 хүнийг ажлаас чөлөөлсөн байна. Мөн түүнчлэн ажлын цагаар, ажлын байранд архи дан согтуурсан бичээчээр ажиллаж байсан Т.Хүрэлмаа, бичээч С.Наранцэцэг, цагаатгалын ажил хариуцсан операторч Ц.Ариунболд, слесарь Б.Ширэндэв, ажил хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа ажлын цагаас хожимдон ажил тасалсан шүүгчийн туслах С.Одгариг, бичээчээр ажиллаж байсан Т.Хүрэлмаа, ажилдаа хайхрамжгүй хандан ажлын хариуцлага алдсан бичээч С.Наранцэцэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй жолоочоор ажиллаж байсан Д.Нямдаваа, жолооч Г.Даваацэрэн, 2001 оны ээлжийн амралтыг хугацаа хэтрүүлэн ажлын 28 хоног ажил тасалсан шүүгчийн туслах Ч.Жаргалсайхан, ажлын 5 хоног ажил тасалсан номын санч Б.Туяанарын ажилтнуудад Хөдөлмөрийн хууль, Байгууллагын дотоод журмыг үндэслэн сахилгын шат дараалсан шийтгэл ногдуулжээ.

Хоёр. Санхүү, материаллаг хангалт, хамт олны нийгмийн асуудлын талаар

Тамгын хэлтэс нь 2001 онд төсвийн хөрөнгийг зохих зүйл ангиар нь аль болох үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр гаргахгүй, өөрийн орлогыг бүрдүүлэн ажиллахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Улсын Дээд шүүхийн 2001 оны батлагдсан төсөв 185,1 сая төгрөг байснаас, Санхүү эдийн засгийн яамнаас 185.1 сая төгрөгийн санхүүжилт авч, түрээсийн орлогыг 4454.8 сая төгрөгөөр бүрдүүлэн, зохих журмын дагуу төсөвт тусган зарцуулж, санхүүгийн мэдээ, тайланг хугацаанд нь тайлагнаж ирлээ. Батлагдсан төсвийн 52 сая төгрөг нь хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн, 133,1 сая төгрөг нь урсгал зардлын төсөв байсан ба төсвийн зардлыг зүйл тус бүрээр нь авч үзвэл:

	<i>Батлагдсан</i>	<i>Зарцуулсан</i>	<i>Хэмнэлт, хэтрэлт</i>
Цалин хөлс	63027.3	58709.3	4318.0
НД Шимтгэл	16639.2	16877.0	327.8
Гэрэл, цахилгаан	2501.8	2174.5	327.3
Түлш, халаалт	13242.7	8814.2	- 4428.5
Тээвэр шатахуун	5969.2	5942.0	- 27.2

Шуудан, холбоо	7212.4	12804.3	5591.9
Цэвэр, бохир ус	905.2	1018.1	+ 112.9
Албан томилолт	1200.0	1858.0	+ 658.0
Бичиг хэрэг	5325.0	6532.8	+ 1207.8
Ерөнхий шүүгчийн байр	303.2	239.1	64.1
Гадаад арга хэмжээ 6000.0	4126.6	1873.4	
Урсгал зардал	500.0	1696.3	+ 1696.3
Нөхөн олговор	4085.6	6647.0	+ 2561.4
Бусад зардалд		6930.4	

байдалтай байна.

Төсөв хөрөнгийн зарцуулалтанд сар бүр дүн шинжилгээ хийж, ялангуяа телефон утасны зардал хэтэрч байсныг багасгах зорилгоор гар утастай харьцах утасны тоог цөөрүүлж, зарим утасны дугаарыг 10,0 мянган төгрөгнөөс хэтрэхгүй ярьж байхаар лимит тогтоолоо.

Улсын Дээд шүүхийн конторын барилгын дээвэр, 1, 2 дугаар давхарууд болон барилгын гадна тал, гол хаалга зэргийг зайлшгүй засварлах шаардлагатай байсан тул уг засварын ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчээр Тендер зарласны дүнд “ХАСУ-МАНДАЛ ТРЕЙД” ХХК шалгарч, уг компани дараахь нэр төрлийн засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

- 1.Барилгын дээврийг иж бүрэн засварласан;
- 2.1, 2 дугаар давхаруудын вестбюльд дүүжин тааз хийсэн;
- 3.2 дугаар давхрын “ОО” өрөөг иж бүрэн засварласан;
- 4.Шүүх хуралдааны танхимын таазыг эмульсдсэн;
- 5.Баруун, зүүн шатны хонгил, вестбюлийг эмульсдэж, шохойдсон, шалыг будсан;
- 6.Дээврээс ус буух хоолойг гүйцээж, цорго шинээр хийсэн.

Дээрх засварын ажлыг хийж гүйцэтгүүлснээс гадна манай байгууллага санал гаргасны үндсэн дээр дараахь нэмэлт засварын ажлуудыг хийлгэлээ. Тухайлбал:

1.Барилгын гадна талын нүүр хэсгийн /фасад/ шавардлага ховхорч унан, зарим хэсгээр хөндийрсэн тул дахин шавардлага хийлгэн терразитан зуурмагаар шүршсэн, урд нүүрний хэсгийг шохойдсон,

2.Цонхнуудын гадна талыг будаж, амалгааг шохойдсон,

3.Гадна үүдний хаалгыг сольж, “Заг констракшен” ХХ Компаний хаалга хийлгэсэн,

4.Гадна үүдний хэсгийн хана болон баганыг иж бүрэн гантигдсан.

Засварын ажлын гүйцэтгэлд төсвөөс 24 сая төгрөгийг зарцуулсан ба батлагдсан төсвөөс хэтэрсэн тул нэмэгдэл засварын ажлын санхүүжилт болох 0.8 сая төгрөгийг манай байгууллага хариуцан гаргасан байна. Барилга засварын ажилд манай байгууллагын талаас багагүй туслалцаа үзүүлж, ялангуяа үйлчилгээний албан хаагчид идэвхи, зүтгэлтэй ажилласнаас үйлчлэгч Я.Боловсүвд, Д.Мөнхравжих, Д.Мөнхжаргал, сантехникч Б.Ширэндэв нар бусдаасаа илүү сайн ажиллаж, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Эрүүгийн болон Иргэний хэргийн Танхимын тэргүүн шүүгч нарын албан хэрэгцээнд ашиглагддаг автомашиныг шинэчлэх зорилгоор ажлын гүйцэтгэлийг шалгаруулах Тендерийн хороо, үнэлгээний ажлын хэсгийг Тамгын хэлтсийн даргын тушаалаар байгуулан, Санхүү, Эдийн засгийн яамтай зөвшилцөж, Тендерийг “Өнөөдөр”, “Зууны мэдээ” сонинуудаар зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Пума констракшен” ХХ Компаниас хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжид зориулсан төсвийн 28 сая төгрөгөөр нь “Соната – 5” маркийн суудлын 2 автомашин худалдан авч, хэвийн ашиглагдаж байна.

Ерөнхий шүүгчийн албан ажлын автомашиныг сайжруулан сүүлийн үеийн “Ниссан патрол” маркийн автомашиныг Төрийн Өмчийн Хорооны тогтоолыг үндэслэн Иргэний тээврийн ерөнхий газраас балансаас балансад шилжүүлэн авч, хэвийн ашиглагдаж байна. Мөн түүнчлэн Төрийн

Өмчийн Хорооны тогтоолын дагуу хуучин Волга-31029, Спортейж маркийн 2 автомашиныг дуудлага худалдаагаар, “Лада” автомашиныг актлан тус тус худалдлаа.

Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны төсвийн төслийг 184.1 сая төгрөгөөр тайлбартайгаар гаргаж, 2001 оны 8-р сарын 15-ны дотор буюу хугацаанд нь СЭЗЯ-нд хүргүүлсэн боловч, 33.1 сая төгрөгийг хасч УИХ 151.8 сая төгрөгөөр баталсан байна.

Дотоод албан томилолтоор Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Увс, Завхан, Сэлэнгэ, Орхон, Тосонцэнгэл, Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг аймгуудад 25 шүүгч, ажилтнууд 1858.0 мянган төгрөгийн зарцуулалттайгаар үйл ажиллагаа явуулжээ.

2001 онд байгууллагын дотоод тохижилт, техник хрэгслэлийн хангалт болон засварлалт, шүүгч, ажилтнуудын ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний нийгмийн баталгааг хангах, зарим хүмүүсийг шагнаж урамшуулах зэрэгт төсвөөс багагүй хөрөнгө зарцууллаа. Тухайлбал:

Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн “Цагаан сар”-ыг тохиолдуулан Ахмад настнууддаа хүндэтгэл үзүүлж 300,0 мянган төгрөг, Ерөнхий шүүгч болон Эрүү, Иргэний хэргийн танхимуудын Тэргүүн шүүгч нарт зориулж 3 ширхэг ус буцалгагч авахад 175,8 мянган төгрөг, хүлээн авалтад зориулж цай, кофений 12 хүний сервис авахад 273,6 мянган төгрөг, Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгчдийн автомашины суудлын бүрээс авахад 65,4 мянган төгрөг, сургалтанд зориулж самбар авахад 150,0 мянган төгрөг, ном хэвлэл худалдан авахад 798,4 мянган төгрөг, Монгол Улсад Шүүх байгуулагдсны 75 жилийн баярын үеэр шагналд зориулан хэрэглэх Хүндэт тэмдэг, Хүндэт тэмдэгний хэв, Улсын Дээд шүүхийн Жуух бичиг, Батламж, Гэрчилгээ зэргийг хэвлүүлэхэд 378,0 мянган төгрөг, Эх, үрсийн баярыг тохиолдуулан шүүгч, ажилтнуудын Ерөнхий боловсролын болон цэцэрлэгийн насны хүүхдүүдэд өгөх бэлгэнд зориулж 300,0 мянган төгрөг, зарим хүмүүсийн 50, 60 насны ойг тохиолдуулан тэдэнд хадаг, мөнгөн аяга зэрэг дурсгалын зүйл өгөхөд 364,1 мянган төгрөг, 2000 оны шинэ жилийн баяраар болон Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан 40 хүнд 1476,0 мянган төгрөг, иж бүрэн компьютер 3 ширхэгийг авахад 2072,4 мянган төгрөг, 1 ширхэг принтер авахад 491,7 мянган төгрөг, 10 ширхэг мауз авахад 65,9 мянган төгрөг, компьютер засварын цахилгаан багаж авахад 32,9 мянган төгрөг, зарим компьютерийг засварлахад 628,1 мянган төгрөг, байгууллагын хэрэгцээнд дүрс бичлэгийн камер авахад 1318,9 мянган төгрөг, зургийн аппарат авахад 333,4 мянган төгрөг, 6 шүүгчийн өрөөнд хивс авахад 404,7 мянган төгрөг, коридорт хөшиг солиход 200,4 мянган төгрөг, шүүх хуралдааны танхимд туузан хөшиг шинээр тавихад 466,7 мянган төгрөг, шүүгч, ажилтнуудын өрөөнд байрлуулах толь авахад 76,0 мянган төгрөг, сантехникийн сэлбэг авахад 798,4 мянган төгрөг, цэвэрлэгээнд зориулж 4 ширхэг тоос сорогч авахад 358,0 мянган төгрөг, 2, 3 дугаар давхрын болон зарим шүүгч, ажилтнуудын өрөөнд өдрийн гэрэл авахад 328,0 мянган төгрөг, 412 тоот өрөөг буюу Цагаатгалын ажил хариуцсан шинжээчийн сууж буй өрөөний шалыг лагдаж засварлахад 280,0 мянган төгрөг автомашинуудыг засаж сэлбэхэд, Тухайлбал: 03-18 УБЗ дугаарын автомашинд 974028 төгрөг, 03-61 УБЗ дугаарын автомашинд 33000 төгрөг, Делика автомашинд 387276 төгрөг, мөн түүнчлэн автомашины даатгал, татвар, оношлогоонд 302076 төгрөгийг тус тус зарцуулж, санхүүгийн тайлан, балансад тусгасан байна.

Мөн түүнчлэн түрээсийн орлого болох 4454,8 мянган төгрөгийг дараах байдлаар зарцуулжээ. Тухайлбал:

Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 75 жилийн ойн семинарын үйл ажиллагаанд 112.2 мянган төгрөг шүүгч, ажилтнуудын идэвхитэй амралтын арга хэмжээнд 500.0 мянган төгрөг, Ахмадын баярын арга хэмжээнд 130.0 мянган төгрөг, гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, хүндэтгэлийн зоог барих, тэдэнд бэлэг дурсгалын зүйл өгөх зэрэгт 881,7 мянган төгрөг, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны 16 удаагийн 40 өдрийн шүүх хуралдаанд оролцогчдын цай, печены үнэнд 206.1 мянган төгрөг, баяр ёслолын үеэр шагнагдсан болон 50, 60 насны ой нь тохиосон шүүгч, ажилтнуудад хадаг, мөнгөн аяга зэрэг дурсгалын зүйл өгөхөд 432,8 мянган төгрөг, өндөр настан Цэрэн-Очир, Зэнэмэдэр нарын хүмүүст буцалтгүй тусламжинд 90.0 мянган төгрөг, цэвэрлэгээний агааржуулагч, үнэр дарагч, арц, хүж, хивс цэвэрлэгч гэх мэт материалд зориулж 42.7 мянган төгрөг, зарим өрөөний хаалганы цоожийг солиход 53.5 мянган төгрөг, хуулийн төв байгууллагуудын дунд зохиогдсон тэмцээний үйл ажиллагаанд сагс, волейболын бөмбөг авахад 38.0 мянган төгрөг, тэмцээний бэлтгэлд 14.0 мянган төгрөг, футболк 14.0 мянган төгрөг, 6 хүнд шагнал гардуулахад 30.0 мянган төгрөг, тэмцээнд оролцогчдын хоолонд 48.0 мянган төгрөг нийт 144.0 мянган төгрөг, “Баян-Уул” амралтанд шүүгч, ажилтанууд чөлөөт цагаа өнгөрүүлэхэд 163.8 мянган төгрөг, бусад зардалд луртасгагч, түлхүүр олшруулах, эвдэрсэн хонх засуулах, 3 давхрын 00-ын өрөөний угаалтуурын цорго засуулах, 2 давхрын 00-ын өрөөнд толь тавих, 4 давхрын 00-ын

өрөөний шалыг засах зэрэг 300.0 мянган төгрөг, шинэ жилийн мэндчилгээнд 92.0 мянган төгрөг, шинэ жилийн баярын арга хэмжээний урьдчилгаанд 330.0 мянган төгрөг, гэр хороололд амьдардаг ажилтнуудад өгөх нүүрсний үнэнд 80.0 мянган төгрөг, эмчийн цалинд 180,0 мянган төгрөг тус тус зарцуулж, 239.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шүүгч, ажилтнуудаас удаан хугацаагаар эмчилгээ хийлгэх болсон, ар гэрт нь гачигдал тохиолдсон, өндөр насны тэтгэвэрт гарсан, амьдрал ахуй нь хүнд нөхцөлд байгаа зэрэг 12 хүнд 1124.2 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосноос гадна эмнэлэгт хэвтсэн болон гэрээр акт авч эмчлүүлсэн 19 хүнд 95000 төгрөгийн дэмжлэг тусалцааг халамжийн сангаас олгожээ.

Монгол Улсад Шүүх байгуулагдсаны 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үеэр бүх ахмад настнууддаа “Манзширын хийд” үзүүлснээс гадна шүүгч, ажилтнуудын идэвхтэй амралтыг 2 удаа зохион байгууллаа.

Гэр хороололд амьдардаг 9 хүнд 5 тн нүүрсийг Налайхаас ачуулан авчран, хуваан өгч, Делика автомашинаар гэр гэрт нь хүргэн өгсөн.

Шүүгч ажилтнуудад зориулж, цайны газар ажиллуулан, тэдэнд хөнгөлттэй үнийн хоолоор үйлчлүүлж байгаагаас гадна жолооч, харуул, үйлчлэгч нарт өрөө гарган өглөө.

“Мон-Дуулга” ХХКомпаниар цахилгааны дүгнэлт гаргуулсны үндсэн дээр Улсын хяналтын албанд санал болгож цахилгаан, барилгын даац, сантехникийн талаар улсын байцаагчийн дүгнэлт гаргуулснаас гадна цахилгааны автоматуудыг сольж, тасарсан кабель утсуудыг болон эвдэрсэн цахилгааны разеткуудыг галын аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн засварласан байна.

Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсээс өгсөн сануулгын дагуу гал гарсан үед гарах гарцыг харуулсан схем бүхий галын самбар хийж, 2 дугаар давхрын вестибюльд байрлуулан, архивын өрөөний гэрлийг өдрийн гэрлээр сольж, цонхонд нь хаалт хийн торлож, хаалгыг нь төмөрлөн бэхэлж, галын хор, галын гидрант шланг, хошуу авч архивт тавьж, Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтэст албан тоотоор хариу өгсөн байна. Мөн түүнчлэн 4 дүгээр давхрын “00” өрөөний шалыг плитадаж, шинээр хаалга хийн, хагарсан 8 цонхыг шиллэн, эвдэрсэн 10 сандлыг засварлаж, цэвэр усны оролтонд тоолуур тавьж, хяналт тавин ажиллаж байна.

Энэ оны 5 дугаар сард улс орон даяар автотехникийн улсын үзлэгт байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа 6 автомашиныг оруулж, техникийн оношлогоо тогтоолголоо.

Байгууллагын гадна баруун талд гадны машин зогсоохгүйн тулд шон будаж тавьсан байна.

Улсын Дээд шүүхийн тамгын хэлтсийн даргын 2001 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 35 дугаар тушаалаар байгуулсан тооллогын комисс нь ажлын 14 хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгийг карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг нярав – нягтлан бодогчийн бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр 310 нэрийн 86 242 087 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, 173 нэрийн 79 956 435.80 төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, 90 нэрийн 4 153 454 төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, 80 301 320 төгрөгийн үнэтэй 6 автомашин, 793 711 төгрөгийн үнэ бүхий 1290 ширхэг орос ном, 2 342 851 төгрөгийн үнэ бүхий 501 нэрийн 788 ширхэг англи ном, 42 нэрийн 47 ширхэг герман ном, бүгд 3724 ном тоологдов. Тооллогын явцад торгон болон торон хөшиг, коридорийн хивс, диваны бүрээс зэрэг материалуудыг нягтлан бодогчийн бүртгэлд метрээр үнэлэгдсэнийг ширхэгт шилжүүлэн тооллоо. Акталж данснаас хасах шаардлагатай эд хөрөнгийн жагсаалт гарган, Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл авч шийдвэрлэхээр болов.

Гурав.Сургалтын талаар

2001 онд Тамгын хэлтсийн ажилтнууд болон шүүгчийн туслахууд сургалт, семинаруудад идэвхтэй оролцлоо. Тухайлбал:

АНУ-ын Адвокат интернейшнл” байгууллага, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн ”Монголын эдийн засгийн эрх зүйн шинэтгэл” төсөл, Олон нийтийн санал бодлын судалгааны ”Сант марал” төв, Монгол банк, Гаалийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, Монголын өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ”Үндсэн хуулийг дээдлэх, Шүүхийн хараат бус байдал, Шүүгчийн ёс зүй”, ”Социологийн онол, арга зүй”, ”Банкны хууль тогтоомж”, ”Гаалийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нэг мөр ойлгох, зөв хэрэглэх”, ”Шүүхийн шийдвэр бүр заавал биелэгдэх ёстой”, ”Хүний эрх, шүүх ба өмгөөлөл” зэрэг сэдэвт семинаруудыг Тамгын хэлтсийн ажилтанууд зохион байгуулалцаж, шүүгчид, шүүгчийн туслахууд, нарийн бичгийн дарга нар, холбогдох байгууллагуудын төлөөлөгчид оролцсон байна.

Манай шүүгч, ажилтнууд өөрсдийн мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд, ялангуяа гадаад хэл сурах талаар онцгой анхаарч, шамдан суралцаж байгаа нь сайшаалтай байна. Тухайлбал:

”Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн төслийн хүрээнд ”Сантил боловсролын төв”-ийн гадаад хэлний сургалтын төвд Англи хэлний 6 сарын дамжаанд Ерөнхий шүүгчийн туслах Ц.Цогт, Судалгааны төвийн мэргэжилтэн, шүүгчийн туслах С.Одгариг, Н.Дуламсүрэн, кодифаикаторч Ц.Нарангэрэл нар, Улсын Дээд шүүх дээр АНУ-ын Адвокат интернейшнл байгууллагын дэмжлэгтэйгээр зохион явуулж буй Англи хэлний сургалтанд шүүгч Д.Мөнхтуул, Ерөнхий шүүгчийн туслах Ц.Цогт, Судалгааны төвийн мэргэжилтэн, шүүгчийн туслах Н.Дуламсүрэн, Б.Оюунбилэг, Ерөнхий шүүгчийн туслах П.Машбаяр, нарийн бичгийн дарга Г.Оюунгэрэл, Д.Батбаатар, номын санч Д.Туяа нар амжилттай суралцаж байна.

Бичиг хэргийн эрхлэгч Засгийн Газрын Хэрэг эрхлэх газраас зохион явуулсан ”Бичиг хэргийн ажилтнуудад зориулсан программ хангамж”-ийн 3 хоногийн сургалтанд, архив хариуцсан ажилтан Хансс-Зайделийн сангийн ”Эрх зүйн боловсрол” академиас зохион явуулсан 3 хоногийн сургалтанд тус тус хамрагдсан байна.

2001 онд Тамгын хэлтсийн ажилтнууд өмнөө тавьсан зорилтоо ерөнхийдөө биелүүлж ажилласан гэж дүгнэж байна.

Улиран өнгөрч буй 2001 онд бусдаасаа илүү идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Ерөнхий шүүгчийн туслах Ц.Цогт, Судалгааны төвийн мэргэжилтэн, шүүгчийн туслах Ц.Ичинхорлоо, Г.Буяннэмэх, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэчимэг, өргөдөл, гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Ё.Цэрэндэжид, цагаатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Чойням, Р.Ишцог, хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, ня-бо Б.Хишигсүрэн, бичээч Д.Оюунчимэг, С.Наранцэцэг, жолооч Г.Батчулуун, слесарь Б.Ширэндэв, үйлчлэгч Цэцэгсүрэн, Я.Болорсүвд, Д.Уртнасан нарт хамт олныхоо өмнөөс талархал илэрхийлж, ажлын өндөр амжилт хүсье.

Цаашид тамгын хэлтсийн ажилтнууд ажлын байрны тодорхойлолтонд тавигдсан шаардлага, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ чанд биелүүлж, юуны өмнө ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилга, дэг журмыг сахих, ажлын цагыг ягштал баримталж, өөртөө тавих шаардлагаа өндөржүүлэн, идэвх санаачлага гарган ажиллана гэдэгт итгэл төгс байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ХЭЛТЭС